

НЭЭЛТТЭЙ академи

Монгол улсын ерөнхийлөгчийн
ивээл дор зохион байгуулсан
Залуу судлаачдын үндэсний анхдугаар
форумын нийгмийн бодлогын салбар
хуралдааны илтгэл

ХҮНИЙ ХӨГЖИЛ, НИЙГМИЙН БОДЛОГО

ЭНЭ НОМЫГ
НЭЭЛТТЭЙ НИЙГЭМ
ФОРУМААС
ХАНДИВЛАВ

Улаанбаатар хот
2005 оны 4 дүгээр сарын 15

Хүний хөгжил-нийгмийн бодлого

Залуу судлаачдын үндэсний анхдугаар
форум

Улаанбаатар хот
2005.04.15

Нийгмийн бодлогын судалгааны баг

Нийгмийн бодлого – хүн



Судалгааны арга зүй

- Судалгааны хоёрдогч эх сурвалж дээр тулгуурласан,
- зарим тохиолдолд жижиг хэмжээнд анкетын судалгаа хийсэн
- Уулзалт ярилцлага хийсэн
- Харьцуулсан судалгаа хийсэн

Өнөөгийн байдал

Бичиг үсэггүй - 34,0; цэцэрлэгт 90,2; ЕБС-537,3;
МЭ - 21,5; ИД - 108,7

Номын сангийн тоо – 268 -284422 хүн
Мэргэжлийн урлагийн тоглолт -3272 удаа 748900 хүн
Соёлын төв-333, арга хэмжээ-21572
Театр, чуулга, циркийн байгууллага-30 -269633 хүн
Музей-33 – 245584 хүн

1000 хүн оногдох
Төрөлт-27,6
Нас баралт – 6
Цэвэр өлөлт - 11

Даатгуулагчийн тоо 556051
Тэтгээр авагч 226.8
Халамжийн тэтгэвэр авагч - 230946

Хүн амын 36,6% ядуу, үүнээс 1% нэн ядуу

Ажилгүйчүүд - 266300
Бүртгэлтэй ажилгүйчүүд - 35571

Нийгмийн үйлчилгээ

Боловсрол

Цэцэрлэг 687 (хувийн 19, байгууллагын 24, төрийн 644) хамрагдал 94%

ЕБС 889 (төрийн 582, төрийн бус өмчийн 107) суурь боловсролын хамран судалтын цэвэр жин 90,4% бага боловсролоос бүрэн дунд боловсрол төгсгөл суралцах дундаж хугацаа 8 жил

Мэргэжлийн сургууль 38

Их дээд сургууль, коллеж 183, (төрийн 48, хувийн 128) төгсөгчдийн жил архлэлтийн түвшин 73%, бага боловсролоос их дээд сургууль төгсгөл суралцах дундаж хугацаа 10 жил

Нийгмийн үйлчилгээ

Боловсрол

- Спортын төвүүд
- Номын сан

Соёлын төв
Музей
Театр чуулга
Кинотеатр зэрэг байгууллагуудаар Соёл, урлагын үйлчилгээг хүргэдэг.

Эдгээрээс спортын байгууллагууд илүүтэй ажиллаж байна.

Нийгмийн үйлчилгээ



Нийгмийн үйлчилгээ



Нийгмийн үйлчилгээ



Нийгмийн үйлчилгээ



Тулгамдаж буй асуудлууд



Санал зөвлөмж

- Нийгмийн бодлогын салбарыг хэрэгжүүлж буй хөтөлбөр, стратеги, зорилтыг үндсэн Хуулийн болон салбарын эрх зүйн орчинтой уялдуулах
- Нийгмийн бодлогын салбарын хамгийн тулгамдсан асуудлуудыг үг нь ажиггүйдэл, ядуурал бөгөөд үүнийг болон бусад асуудлыг шийдвэрлэхэд боловсролын үүрэг нөлөөг эгмэгдүүлж, боловсролоор дамжуулан нийгмийн бодлогын асуудлыг шийдэх стратеги хэрэгжүүлэх
- Хүнийг-нийгмийн бодлогын цөмд тавьж, асуудал-ойрсон бус хүнд төвлөрсөн цогц бодлого хэрэгжүүлэх
- Хүн нь нийгмийн үнэт капитал болохын хувьд нийгмийн хамгаалал хэмээх төрийн дархлаажуулалтын тэгш боломжоор хангагдах
- Төр нь хүнээс хүн нь хүнээ хүндэлсэнээрөө дээдэлсэн, хууль зүйн захирагдсан, ирээдүйд баримжаалсан, оюунд шүтсэн, ядуу аж төрөхөд чиглэсэн нийгмийн харилцаа, хэм хэмжээг хөгжлийн баримжаа болгох

Нийгмийн бодлогын салбар хуралдаанаас гаргасан зөвлөмжийн төсөл

Нийгмийн бодлогын зорилт нь:

- Нийгмийн бодлогын салбарт хэрэгжүүлж буй хөтөлбөр, стратеги, үйл ажиллагааг Үндсэн Хуулийн болон салбарын эрх зүйн орчинтой уялдуулах,
- Нийгмийн бодлогын салбарын хамгийн тулгамдсан асуудлуудын нэг нь ажилгүйдэл, ядуурал бөгөөд үүнийг болон бусад асуудлыг шийдвэрлэхэд боловсролын үүрэг нөлөөг нэмэгдүүлж, боловсролоор дамжуулан нийгмийн бодлогын асуудлыг шийдэх стратеги хэрэгжүүлэх,
- Хүнийг нийгмийн бодлогын цөмд тавьж, ,
- Хүн нь нийгмийн үнэт капитал болохын хувьд нийгмийн хамгаалал хэмээх төрийн дархлаажуулалтын тэгш боломжоор хангагдах,
- Төр нь хүнээ, хүн нь хүнээ хүндэлсэн, төрөө дээдэлсэн, хууль зүйд захирагдсан, ирээдүйд баримжаалсан, оюунд шүтсэн, эрүүл аж төрөхөд чиглэсэн нийгмийн харилцаа, хэм хэмжээг хөгжлийн баримжаа болгоход чиглэгдэнэ.

Судалгаанд хамрагдсан чиглэл тус бүрээр дараахь зүйлийг зөвлөмж байна. Үүнд:

Боловсролын талаар:

- Хүний хөгжлийн эх сурвалж болохын хувьд хүн амын бичиг үсгийн үйл ажиллагааны чадварыг үнэлэх орчин үеийн жишиг нэвтрүүлж, хүн бие даан тасралтгүй хөгжих нийгмийн боломж бүрдүүлэх
- Боловсролын чанарыг дээшлүүлэх үндсэн арга зам нь багш суралцагчийн харилцааг хамтран ажиллагчийн харилцаанд хүртэл хөгжүүлж, суралцагч өөрийн онцлог, хэрэгцээ, боломжид тулгуурлан суралцах явдал мөн.
- Боловсрол эзэмших тогтолцооны бүтцийн гажиг болж буй мэргэжлийн сургалт-дээд боловсролын урвуу хамаарал, сургалт оройтож эхлэх, суралцах хугацаа богино байх, сургалтын агуулга, зохион байгуулалт, арга зүй хувилбаргүй байх, шалгалт, үнэлгээгээр суралцагчийг ялгаварлан гадуурхаж, дарамтлах зэрэг сөрөг хандлагыг илааршуулах

Ядуурал, ажилгүйдэл, нийгмийн хамгаалалын талаар:

- Ядуурал, ажилгүйдлийг бууруулах талаарх хөрөнгийн зарцуулалтын гүйцэтгэлд тавих засаг захиргааны байгууллагын хяналтыг бий болгож, хэрэгжүүлэх
- Ядууралд зарцуулж буй хөрөнгийг ажлын байр бий болгох, жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих зорилгод чиглүүлэх бодлогыг төрөөс баримтлах, ингэснээр бэлэнчлэх сэтгэлгээг арилгах
- Хүн амд хүрч байгаа төрийн үйлчилгээний жигд бус байдал нь засаг захиргааны нэгжийн хувиарлалтын тэнцвэргүй байдалтай холбоотой

- учраас засаг захиргааны анхдагч нэгжид хамаарах хүн амын тоог хот хөдөөд тэнцвэржүүлэх
- Төрийн захиргааны ажилтан үйлчилгээний ажилтныг улс төрөөс ангид байлгаж, тогтвортой ажиллах боломжийг хууль, эрх зүйн орчинд бүрдүүлэх
 - “Ядуу” гэсэн тодорхойлолтыг өрхөөр авч үзэн, өрх (гэр бүл)-д тулгуурласан орон нутгийн эдийн засаг, зах зээлийн онцлогт нийцүүлэн шинээр тодорхойлж хэрэгжүүлэх
 - НДШ-ийн хувь хэмжээг одоогийн хуульд зааж байгаагаас багасгах,

Эрүүл мэндийн салбарт:

- Төрөөс эрүүл мэндийн салбарт зарцуулж буй хөрөнгө хүн амын эрүүл мэндийн өсөн нэмэгдэж байгаа хэрэгцээг тэр бүр хангаж чадахгүй учраас хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэхэд түлхүү анхаарах. Улсын эмнэлэгийг хувьчлах аргыг зөв сонгохдоо (*удирдлагын гэрээгээр, гүйцэтгэлийн гэрээгээр эсвэл бүрэн хэмжээгээр худалдах*) иргэн бүрт эмнэлэгийн чанартай үйлчилгээг тэгш хүргэх, эмнэлэгийн тоног, төхөөрөмж, багаж хэрэгсэл, үл хөдлөх хөрөнгийн хувьчлал биш, харин нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, эмнэлэгийн тусламж үйлчилгээг хувийн хэвшилд шилжүүлэх. Өрхийн эмнэлэг нь хувийн хэвшилд хамаарах уу, эсвэл улсын эмнэлэг үйлчилгээний байгууллага уу гэдгийг нарийвчлан түүний статусыг тодорхойлон эрх зүйн зохицуулалтыг бий болгох.
- Эрүүл мэндийн даатгалын тогтолцоог боловсронгуй болгох, гадаадын зарим улс орны эрүүл мэндийн даатгалын харилцааг зохицуулсан эх сурвалжийг судалсаны үндсэн дээр энэхүү даатгалын санхүүжилтийн эх үүсвэр, түүнийг хуваарилах, хэрэгжилтэнд нь хяналт тавих зохицуулалтыг бий болгох.
- Эмнэлэгийн байгууллагын хяналт, хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгож, эмч мэргэжилтнүүдийн ур чадварыг дээшлүүлэн, эмчилгээ оношилгооны техникийн чадавхийг сайжруулсны үндсэн дээр нийгмийн эрүүл мэндийн үйлчилгээний чанарыг дээшлүүлнэ.

Соёлын талаар:

- Нийгмийн өнөөгийн өөрчлөлт шинэчлэлтийн үед монгол үндэсний соёл, уламжлал, ёс заншил алдагдахаас сэргийлэх, түүнийг хадгалж үлдээхэд төрөөс онцгой анхаарах
- Монгол улсын соёл, урлагийн байгууллагуудад төрөөс хуваарилж байгаа төсвийн санхүүжилтийг эрс нэмэгдүүлэх, тэдгээрийн хангамж, ажиллах нөхцлийг сайжруулах (ялангуяа хөдөө орон нутагт), соёлын үнэлэмжийг дээшлүүлэх, соёлын маркетинг, менежментийг зөв оновчтой зохион байгуулах
- Иргэдийн соёлын боловсролыг нэмэгдүүлэх, хүүхдийг багаас нь үндэсний соёлын мэдрэмжтэй болгон хүмүүжүүлэх, бүх шатны боловсролын тогтолцоог соёлын призмээр дамжуулан харах,

ХҮНИЙ ХӨГЖИЛ, НИЙГМИЙН БОДЛОГО

Монгол Улс нь 2.5 сая хүн амтай, тэдгээрийн суурьшил сийрэг таруу, далайд гарцгүй хөгжиж буй орон юм. Шилжилтийн эхэн үе болох 1990-94 онд эдийн засаг огцом уналтанд орж, үндэсний орлого эрс буурсан. Ажилгүйдэл газар авч, ядуурал нэмэгдэн, гудамжны хүүхэд, орон гэргүй хүмүүс, гэмт хэрэг, архидалт зэрэг нийгмийн сөрөг үзэгдлүүд гарах болсон. 2000 оны 9 дүгээр сард зохион байгуулагдсан Нэгдсэн Үндэстний Мянганы Чуулга уулзалтаас Мянганы тунхаглалыг зарласан. Энэхүү тунхаглалыг хэрэгжүүлэх хүрээнд 2001 оны 9 дүгээр сард зохион байгуулсан НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 56 дугаар чуулганаас Мянганы хөгжлийн зорилт, түүний шалгуур үзүүлэлтүүдийг дэвшүүлж тавьсан. Энэ нь:

- 1000 амьд төрөлтөд ногдох нялхсын эндэгдэл
- 5 хүртэлх насны 1000 хүүхдэд ногдох нас баралт
- Бага боловсролын хамран сургалтын цэвэр жин
- 5-р анги хүртэл суралцагчдын хувь
- 1 доллараас бага өдрийн хэрэглээтэй хүн ам
- Дундаж наслалт
- Хүүхдийн хүнс тэжээлийн хомсдол
- Цэвэр усаар хангагдсан хүн амын эзлэх хувь
- Насанд хүрэгчдийн бичиг үсэг, боловсролын түвшин
- Хэрэглээний үнийн түвшин
- Монгол улсын нийгмийн бодлогын салбарын өнөөгийн байдлыг авч үзье.

I. Монгол Улсын нийгмийн хөгжлийн өнөөгийн байдал

Боловсрол. 2000 онд Монгол Улс хүн ам, орон сууцны тооллого явуулсан. Энэ тооллогын үр дүнд хэд хэдэн төрлийн анализ хийсний нэг нь хүн амын тооллогын мэдээнд боловсрол, бичиг үсгийн байдлаар нь тусгайлан хийсэн анализ, дүгнэлт юм. 2000 оны байдлаар насанд хүрэгчдийн (15 ба түүнээс дээш насны) бичиг үсгийн боловсролын түвшин 97.8 хувьтай байна. Бичиг үсэг үл мэдэгчдийн хувь 2.2 хувь байгаа нь 1524372 насанд хүрэгчдээс 33536 хүн бичиг үсэггүй байна гэсэн үг юм.

Хүснэгт 1. Насанд хүрэгчдийн боловсролын түвшин 1979, 1989, 2000 оны хүн амын тооллогын мэдээгээр

	Бичиг үсэггүй	Бичиг үсэгтэй	Бага	Бүрэн бус дунд	Бүрэн дунд	Диплом	Боловсролын зэрэг
1979 он							
Бүгд	7.3	11.4	29.0	28.4	9.8	7.9	6.2
эрэгтэй	3.9	11.6	28.8	32.5	9.2	6.6	7.4
эмэгтэй	10.6	11.3	29.1	24.3	10.4	9.3	5.0
1989 он							
Бүгд	3.5	6.0	20.5	33.9	18.1	9.6	8.5
эрэгтэй	1.8	5.0	19.7	38.8	17.6	7.4	9.8
эмэгтэй	5.1	7.0	21.4	29.0	18.6	11.7	7.2
2000 он							
Бүгд	2.2	3.2	16.4	30.1	29.7	9.2	9.2
эрэгтэй	2.0	3.1	17	34	27.8	6.9	9.2
эмэгтэй	2.5	3.4	15.8	26.2	31.6	11.3	9.2

Эх сурвалж: National Statistical Office. (2000). Population and housing census 2000. Education and Literacy: Analysis based on the 2000 census. Ulaanbaatar.


Монгол Улсын боловсролын тогтолцоо нь 4 жилийн цэцэрлэг, 4 жилийн бага боловсрол, 4 жилийн бүрэн бус дунд боловсрол, 2 жилийн бүрэн боловсрол, 1-3 жилийн техникийн болон мэргэжлийн боловсрол, 3 жилийн дипломын боловсрол, 1-2 жилийн баклавын боловсрол, 1-2 жилийн магистрын боловсрол, 3-4 жилийн докторын боловсролоос бүрдэж байна. Сургуульд элсэх нас 8 нас бөгөөд 2003 оны шинэчлэн найруулсан боловсролын хуулиар энэ насыг 7 болгож өөрчилсөн нь 2004-2005 оны хичээлийн жилээс мөрдөгдөж эхэлсэн. Ерөнхий боловсролын 10 жилийн сургалтын тогтолцооноос 11 жилийн сургалтын тогтолцоонд шилжиж байгаа бөгөөд 2004-2005 оны хичээлийн жилд 11 жилийн сургалтын тогтолцооны анхны анги "0" бүлэг нэртэйгээр хичээллэж байна. 2005-2006 оноос 11 жилийн сургалтын тогтолцоонд шилжих шилжилтийн хөтөлбөрөөр хичээллэж, 2006-2007 оны хичээлийн жилд 11 жилийн тогтолцоонд бүрэн утгаараа шилжих юм. Засгийн газрын дэвшүүлж буй зорилтын дагуу 2009-2010 оны хичээлийн жилээс 12 жилийн сургалтын тогтолцоонд шилжих бэлтгэл судалгаа хийгдэж байна.

Боловсролын салбарын тогтолцоог авч үзвэл цэцэрлэгт хамрагдах хүүхдийн тоо 1994 оноос тасралтгүй нэмэгдсээр байгаа боловч 1990 оны түвшиндээ хүрээгүй байна.

2003-2004 оны хичээлийн жилийн байдлаар 644 цэцэрлэгт 90215 хүүхэд суралцаж байгаа бөгөөд цэцэрлэгээс бусад хэлбэрийн сургуулийн өмнөх боловсролын байгууллага нэмэгдэж байна.

Ерөнхий боловсролын дунд сургуульд 8-18 насны хүүхдүүд суралцдаг бөгөөд сүүлийн үед 8 наснаас өмнө сургуульд суух хандлага нэмэгдэж байна. 2003-2004 оны хичээлийн жилд 7 хүртлэх настай 3080, 7 настай 24384 хүүхдэд суралцаж байгаа нь нийт сургуульд суралцаж байгаа хүүхдүүдийн 5 хувь, бага ангийн хүүхдүүдийн 12 хувь эзэлж байгаа нь өндөр хувь байна.

График 3. ЕБС-д суралцагчдын тоо



Эх сурвалж: БСШУЯ-ны статистик мэдээ

2003-2004 оны хичээлийн жилийн мэдээгээр ерөнхий боловсролын 686 сургуульд 537398 хүүхэд суралцаж байна. Монгол улсын үндсэн хуулийн дагуу монгол улсын иргэд суурь боловсролыг үнэ төлбөргүй эзэмших эрхтэй.

Хүснэгт 2. Суурь боловсролын хамран сургалтын цэвэр жин


Он	1990	2000	2003
8-15 насны хүн ам	404842	503376	478537
Сургуульд суудаг 8-15 насны хүүхэд	378486	435221	432661
Сургуулийн гадна байгаа сургуулийн насны хүүхдийн тоо	26356	68155	45876
Хамран сургалтын цэвэр жин	93.5	86.5	90.4

Эх сурвалж: БСШУЯ-ны статистик мэдээ

2003-2004 оны хичээлийн жилийн байдлаар бага боловсролын буюу 8-11 насны хүүхдийн хамран сургалтын цэвэр жин 87.5 хувь, сүүлийн жилүүдэд нэг жилд дунджаар 11000 гаруй хүүхэд сургууль завсардаж байна.

Мэргэжилтэй ажилтан бэлтгэх үндсэн тогтолцоо нь техникийн болон мэргэжлийн сургуулиар хэрэгждэг. 2003-2004 оны хичээлийн жилийн байдлаар техникийн болон мэргэжлийн 38 сургуульд 21574 суралцагч сурч байна.

График 4. Техникийн болон мэргэжлийн сургуульд суралцагчдын тоо



Эх сурвалж: БСШУЯ-ны статистик мэдээ

Коллеж, дээд сургууль, их сургуулиар дипломын дээд боловсрол, боловсролын бакалавр, магистр, докторын зэргээр суралцаж байна. 2003-2004 оны хичээлийн жилд 183 сургуульд 108738 оюутан суралцаж байгаагаас дипломын боловсролоор 6128, бакалавр 96504, магистрантурт 4491, доктортурт 1615 суралцагч байна.

Дээд боловсролын байгууллагын тоо 1990 онтой харьцуулбал 23 дахин, түүнд суралцагчдын тоо 6.3 хувиар өсжээ.

Хөдөлмөрийн зах зээл дээр дээд боловсролтой хүний тоо хэрэгцээт ажлын байрнаасаа илүүдэж, харин мэргэжилтэй ажилчин шаардагдах ажлын байрны эрэлт өдрөөс өдөрт нэмэгдэж байна.

Хүснэгт 3. Төгсөгчид, ажлын байртай болсон төгсөгчдийн харьцаа

	2000-2001		2001-2002		2002-2003		2003-2004	
	Бүгд	эм	Бүгд	эм	Бүгд	эм	Бүгд	эм
Төгсөгчийн тоо	14868	9753	17671	11767	18289	11795	21109	13770
Ажилтай болсон	1947		3731		4824		7037	
Хувь	13.0		21.1		26.3		33.3	

Эрүүл мэнд. 1500 гаруй эмнэлэгийн байгууллага байгаагаас хэвтэн эмчлүүлэх 513, асрамжийн 20, амбулаторын үйлчилгээ 735, эм эмнэлэгийн хэрэгслийн худалдаа эрхэлдэг байгууллага 234 байгууллага байна.

Бүтэц нь засаг захиргааны нэгжээ дагасан


Нарийн мэргэжлийн үйлчилгээ үзүүлдэг төв, эмнэлэг, хувийн эмнэлэгийн 58.6% Улаанбаатар хотод байна.

Эрүүл мэндийн байгууллагуудын 29.8%/467/ нь улсын, 70.2%/360/ нь хувийн байгууллага байна.

Нэг эмчид 375 хүн оногдож байна.

Эрүүл мэндийн салбарын үйл ажиллагааны чанар, үр нөлөөг дээшлүүлэх талаар эрүүл мэндийн салбарт ажиллаж байгаа болон иргэдийн төлөөллөөс судалгаа явуулсан юм. Судалгаанд оролцогчдын 58 хувь нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хангалтгүй байгаа гэж дүгнэсэн бөгөөд хангалтгүй гэж дүгнэсний учир шалтгаанд олон зүйлийг нэрлэсэн бөгөөд 43 хувь нь улсын эмнэлэгт хүнд суртал газар авсан, эмч мэргэжилтнүүдийн цалин хангамж, нийгмийн асуудлыг шийдвэрлэж чадаагүй, тэднийг сайн ажиллуулах хөшүүрэг байхгүй, эмч нарыг бэлтгэдэг сургалтын чанар муудсан, эмнэлгийн ажилтнуудын хүний төлөө ажиллах сэтгэл ёс зүйтэй холбон үзсэн бол 31 хувь нь иргэдийн эрүүл мэндийн боловсролын түвшин хангалтгүй учраас түүндээ тохирсон үйлчилгээ авдаг ба эрүүл мэндээ хамгаалуулах эрхээ эдэлж чаддаггүй гэж тодорхойлсон байна.

Иргэдийн эрүүл мэндийн боловсролын түвшинг дээшлүүлэх нь илүү мэдээлэлтэй өвчтөн илүү чанартай тусламж авдагтай шууд холбоотой, эмнэлгийн байгууллагад хандаж байгаа иргэн эдлэх эрхээ мэддэг байх нь эмчилгээний үр дүнд нөлөөтэй учраас эрүүл мэндийн боловсролын түвшинг дээшлүүлэх зайлшгүй шаардлагатай байна. Ингэснээр иргэн эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээг илүүтэй хүргэх боломжтой юм. Гэхдээ эмнэлгийн тусламж үйлчилгээг төлбөрийн чадвар багатай, ядуу иргэд ядуу бус иргэдтэй харьцуулахад харьцангуй бага хүртэж байгааг дараах судалгаанаас харж болно.



Эх сурвалж: Өрхийн орлого, зарлага, амьжиргааны түвшний түүвэр судалгааны үндсэн тайлан.

Соёл, урлаг.

1. Спортын төв
2. Номын сан
3. Соёлын төвүүд
4. Музей
5. Театр, чуулга
6. Кино театр зэрэг байгууллагуудаар соёл, үйлчилгээг хүргэдэг. Эдгээрээс спортын байгууллагууд илүүтэй ажиллаж байна.

Монголд үйлчилгээ үзүүлж байгаа соёлын байгууллагуудын тоо

1. Театр, чуулга, циркийн байгууллага 30, шинэ уран бүтээл 104, хүүхдэд зориулсан тоглолт 860, хүүхэд нийт үзэгчдийн 269633
2. Номын сан 268, уншигчдын тоо 1120587, байнгийн 284422, ирэгсэд 836165
3. Музей 33, үзэгчдийн тоо 245584, хүүхэд 113264, гадаад 49215, бусад 83375
4. Соёлын төв 333, зохион байгуулсан арга хэмжээ 31572.

Орчин үеийн соёлын бодлогын олон улсын нийтлэг чиглэл нь дараах хэдэн чиглэлтэй байна. Үүнд:

- Соёлын үйл ажиллагаанд хүн бүрийн оролцох бололцоог аль болох бүрэн дүүрэн хангах
- Үндэстэн ястны соёлын өвийг хадгалах, хамгаалах, сурталчилах
- Үндэстний хэлний цэвэр ариун байдлыг сахин хамгаалах
- Соёлын удирдлагын тогтолцоон дахь хэт төвлөрлийг саармагжуулан аль болохоор орон нутаг, үндсэн байгууллагын бие даасан бодлогыг хангах
- Соёлын санхүүжилтэнд төрийн болон хувийн хэвшлиүүдийг өргөн татан оролцуулж, соёл урлагт хувийн хэвшлийнхнээс хөрөнгө оруулах явдлыг улсын зээл, татварын бодлогоор дэмжих
- Соёлын харилцааг аль болох нээлттэй байлгах гэсэн зүйлс багтана.

Урлагийн ямар нэг бүтээлийг нийгмийн тодорхой хүрээний хэдхэн хүмүүс үзэж сонирхож байгаа бөгөөд бусад нь дараах хүчин зүйлсээс болж хамрагдаж чадахгүй байна гэж үзэж болох юм. Үүнд:

1. Хувь хүний боловсролын түвшин, мэдлэгийн цар хүрээ
2. Өнөөгийн эдийн засгийн тогтворгүй байдал
3. Нийгмийн дарамт болон ядуурал
4. Урлагын бүтээл чанарлаг бус

Үүнээс харахад зөвхөн хэрэглэгч, үзэгч түмэн маань үзэх сонирхолгүй байгаа гэж ойлгож болохгүй бөгөөд уран бүтээлчид хэр зэрэг чанарлаг уран бүтээл хийхээс бас их шалтгаалж байна. Харин уран бүтээлчид өнөөдөр чанарлаг уран бүтээл туурвихад санхүүгийн асар их бэрхшээлтэй тулгарч байна.

Сүүлийн жилүүдэд манай орны соёлын харилцааны нийгмийн орчин дараах хэд хэдэн чиглэлээр өөрчлөгдөж байна. Үүнд:

- Оюун санааны амьдрал хуучин суртлаасаа ангижирч, либералчлагдсан мөн сэтгэлгээний чөлөөт, олон ургальч байдал эрх зүйн талаар баталгаажсан.
- Соёл урлагийн гадаад орчин түргэн өөрчлөгдөж байгаатай холбоотойгоор хүн амын, ялангуяа өсвөр залуу үеийнхний оюун санааны шинэ шинэ хэрэгцээ үүсэж төлөвшиж байна.
- Монголчууд уламжлалт шашин шүтлэгээ эрчтэй, богино хугацаанд сэргээн хэрэглэх болж хүн амын янз бүрийн хэсгийн амьдралд шашны гүйцэтгэх үүрэг эрс нэмэгдэж байгаа ба үүнээс гадна шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөтэй болсноор харийн шашны янз бүрийн

урсгалууд чөлөөтэй нэвтэрч, хүн амын тодорхой хэсгийн дунд чөлөөтэйгөөр дэлгэрэн түгэж байна.

- Соёл урлагийн удирдлагад хэт төвлөрлийг сааруулж, орон нутаг, үндсэн байгууллага, хувь хүмүүс, уран бүтээлчдийн бие даасан байдлыг дэмжих болсон байна.
- Соёл урлагийн гадаад харилцаа нээлттэй болж, бусад улс орон, ард түмний соёл чөлөөтэй нэвтэрч байна.
- Нийгмийн амьдралын бүх хүрээ зах зээлийн харилцаанд шилжиж байгаа нөхцөлд соёлын удирдлага, менежмент гүйцэд шинэчлэгдээгүй, удирдлагын хуучин хэлбэрээс бүрэн ангижирч чадаагүй байна.
- Зах зээлийн нөхцөлд соёл, урлагийн байгууллагыг хэрхэн ажиллуулах үндэсний үзэл баримтлал, стратегийн чиг шугам тодорхой байгаагийн улмаас тэдгээр байгууллагын бие дааж оршин амьдрах чадвар сул, хөрөнгө санхүүгийн бэрхшээлтэй байнга учирч байна.
- Манай улс огт өөр нийгмийн харилцаанд шилжиж байгаа учраас хүмүүс ертөнцийг үзэх үзэл, амьдралын гүн ухаан, үйл ажиллагааны зорилго чиглэл, аж төрөх ёсон, зан суртахууны тулгуур үнэт зүйлс богино хугацаанд үндсээрээ өөрчлөгдөж байгаа боловч шинэ үзэл баримтлал, үнэт зүйлсийн тогтолцоо гүйцэд төлөвшиж чадаагүй байна..

Эдгээр өөрчлөлтийн ихэнх нь шинэ нийгмийн зорилго, шинж чанарт нийцэн, тохирсон эерэг шинжийг агуулсан байгаа хэдий ч үүний зэрэгцээгээр сөрөг үр дагавар ч багагүй гарч байна. Түүнээс хамгийн гол нь ёс суртахууны уналт бөгөөд энэ нь хүн амын амьдралын нилээд хэсгийн ертөнцийг үзэх үзэл өөрчлөгдөж, нийгэм эдийн засгийн хямралт байдал удааширч, ядуурал газар авснаас иргэдийн ухамсарын түвшин доройтож байна.

Нийгмийн хамгаалал. Нийгмийн хамгаалал нь нийгмийн даатгал, нийгмийн халамж гэсэн хоёр бүрэлдэхүүнтэй.

Ажиллагсадын 87.4% нь заавал даатгалд, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн 4% нь сайн дурын даатгалд хамрагдаж байна. Нийгмийн датгаалын сангаас 174.6 хүн тэтгэвэр авч байна.

НХ-ын 95.4%-ыг төрөөс санхүүжүүлдэг. Сүүлийн 10 жилд хөрөнгийн хэмжээ 3 дахин өсч 4 хүн тутмын 1 нь халамжийн ямар нэгэн тусламж авч байгаа боловч нөлөө нь бага байна.

Зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжсэн шилжилтийн жилүүдэд хүн амын нийгмийн хамгаалалын хэрэгцээ өсч, зардал нь 1996-2000 онд 4.4-7.3 хувь болон нийт төсвийн зардлын 17.7 хувьтай тэнцэж байна. Дээрх хугацаанд нийгмийн салбарт зарцуулах зардал ДНБ-ний 13 хувь байснаа 20 хувь болж өссөн байна. 1997-2000 онуудад нийгмийн халамжийн сангаас тэтгэвэр, тэтгэмжид зарцуулах хөрөнгийн хэмжээ 2 дахин нэмэгдсэн байна. 1998 онд дундаж орлоготой өрхийн нийт орлогод нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн хувь ердөө 0.75 хувь байсан ба энэ нь ядуу өрхийн хувьд 1.3 хувь, нэн ядуу өрхийн хувьд 3.6 хувь байжээ. Нийгмийн хамгаалалын салбарын санхүүжилт нь улсын төсвийн санхүүгийн эх үүсвэрийн бүрдэлт, бэрхшээлээс шалтгаалан зарим талаар хүндрэх явдал байдаг.

/Эх сурвалж: Нийгмийн хамгааллын стратегийн баримт бичиг/

Нийгмийн даатгал. Нийгмийн даатгал нь нийгмийн хамгааллын томоохон үүрэг гүйцэтгэж байна. Монгол улсад даатгуулагч, ажил олгогчоос шимтгэл төлөх замаар тэтгэвэрийн хуримтлал бий болгон түүнээс тэтгэвэр авагчдынхаа тэтгэврийг олгодог хувиарилалтын тогтолцоо үйлчилж байна.

Одоогийн байдлаар нийт хөдөлмөрийн гэрээгээр ажиллагчдын 92.0 хувь нь заавал даатгалд, малчид хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн 22.5 хувь нь сайн дурын даатгалд, нийт хүн амын 92.2 хувь нь эрүүл мэндийн даатгалд тус тус

хамрагдаад байна. Нийт 262.8 мянган тэтгэвэр авагчдын нэг хүнд ноогдох дундаж тэтгэвэр 2002 оны эцсийн байдлаар 25.7 мянган төгрөгт хүрээд байна.

2000 оны хүн ам, орон сууцны тооллогын дүнгээр Монгол улсад 60 ба түүнээс дээш насны хүн амын тоо нийт хүн амын 5.2 хувийг эзэлж байна. Ирэх 25 жилийн хугацаанд Монгол улсын хүн ам 24 хувиар өсөх төлөвтэй байхад 65 ба түүнээс дээш настай хүн амын нийт хүн амд эзлэх хувийн жин 2025 он гэхэд одоогийнхоос бараг 2 дахин буюу 2.4 хувиас 6.4 хувьд хүрч нэмэгдэх төлөвтэй байна.

Улс орны эдийн засгийн нөхцөл байдлаас шалтгаалан тэтгэврийн тогтолцоонд хамрагдаж буй тэтгэвэр авагчдын тэтгэврийн хэмжээ нь 1990 оноос хойшхи үнийн өсөлтөөс бараг 2 дахин хоцорч байгаа нь тэтгэвэр, тэтгэмжийг нэмэгдүүлэх улмаар тэтгэвэрийн даатгалын сангийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх шаардлага, нөгөө талаас бэрхшээл хүндрэлийг гаргаж байна.

Иймээс тэтгэврийн даатгалын “хувиарлалтын” тогтолцооноос “хагас хуримтлалын” тогтолцоонд шилжих, тэтгэврийн шинэчлэлийн бодлогыг хэрэгжүүлэх замаар тэтгэврийн тогтолцоог боловсронгуй болгох явдал тулгамдсан зорилт болж байна.

Нийгмийн даатгалын сангаас олгосон тэтгэвэр

Нийгмийн даатгалын тэтгэврийн төрөл	Өндөр насны	Тэжээгчээ алдсаны	Тахир дутуугийн	Цэргийн	ҮОМШӨ	Нийт
Хүний тоо /мян.хүн/	174.6	35.5	36.3	9.7	6.7	262.8
Дундаж тэтгэвэр /мян.төг/	25.1	18.0	18.5	36.8	30.5	25.7

Эх сурвалж: УНДЕГ

Өнөөгийн байдлаар нийгмийн даатгалын сангууд /тэтгэврийн сангаас бусад нь/ орлогоороо зарлагаа нөхөх зарчмаар бүрдэн ажиллаж байгаа ба тэтгэврийн даатгалын сангийн алдагдалд 1995 оноос өмнө Улсын төсвөөс тэтгэвэр авч байсан хүмүүсийн тэтгэврийн зардал шууд шилжиж ирсэн нь нөлөөлж байна.

Улс орны хувьд тэтгэврийн зардлыг төлж чадахуйц түвшинд байлгахын тулд энэхүү тэтгэврийн шинэ тогтолцоог бий болгосон юм. Тэтгэврийн сангийн хэтийн тооцооноос үзвэл хуучин тогтолцоог хэвээр хадгалах байгаа нөхцөлд даатгалын сангийн орлогоос тэтгэврийн зардал нилээд хэмжээгээр давахаар байна. Түүнчлэн тэтгэврийн хуучин тогтолцоонд шинэчлэл хийхгүй бол сангийн жилийн алдагдал байнга нэмэгдэж ДБН-ий 8 хувьд хүрэхээр байна. Засгийн газар тэтгэврийн сангийн алдагдлыг санхүүжүүлэх боломжгүй учраас одоо даатгалын шимтгэл төлж байгаа ирээдүйн өндөр настнуудын тэтгэврийг баталгаажуулах үүднээс тэтгэврийн тогтолцоонд шинэчлэл хийх зайлшгүй шаардлага гарч байна.

Эрүүл мэндийн даатгалын өнөөгийн тогтолцоо нь эв санааны нэгдлийн зарчмаар байгуулсан сангаас бүх шатны эмнэлэгийн байгууллагад хэвтэн эмчлүүлэх үйлчилгээ, өрхийн эмнэлэг, амбулаторийн зардал, эмийн үнийн хөнгөлөлтийг норматив тарифаар санхүүжүүлэх зарчмаар хэрэгжиж байна. Санхүүжилтын энэ хэлбэр нь эрүүл мэндийн үйлчилгээний чанар үр дүнг сайжруулах зорилттой төдийлөн нийцэхгүй байна.

Өнөөгийн нийгмийн даатгалын тогтолцоо нь Монгол улсын хүн амын нийгмийн хамгааллын үндэс суурь болж байна. Засгийн газар нийгмийн даатгалын үйл ажиллагааг эрхлэн хэрэгжүүлснээр эдийн засгийн бүтцэд гарсан өөрчлөлттэй холбоотой нийгмийн даатгалын тогтолцоог сайжруулах зорилтыг дэвшүүлж хэрэгжүүлж байна. Нийгмийн даатгалын тогтолцоог сайжруулах зорилтын хүрээнд тэтгэврийн даатгалын сангийн санхүүгийн чадавхийг

бэхжүүлэх, тэтгэвэр, тэтгэмж олгох нөхцлийг оновчтой болгох, малчид хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн нийгмийн хамгааллыг сайжруулах, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урдчилан сэргийлэхэд илүүтэй анхаарах, нийгмийн хамгааллын үйлчилгээнд хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх асуудлууд багтаж байна.

2004 оны жилийн эцсийн байдлаар улсын хэмжээнд нийтдээ 35000 гаруй ажлын байр бий болсон ба эдгээрийг эдийн засгийн салбар ангиллаар нь авч үзвэл: барилгын салбарт- 17.8%, бөөний болон жижиглэнгийн худалдааны салбарт –15.1%, хөдөө аж ахуйн салбарт- 11.2%, боловсруулах аж үйлдвэрийн салбарт-10.8%,нийтийн аж ахуйн салбарт –7.5%, уул уурхай, олборлох үйлдвэрлийн салбарт- 6.2%, зочид буудал, зоогийн газар, хөлсний ажигчидтай өрх аж ахуйн салбарт-6.0%, тээвэр холбооны салбарт- 4.1%, үл хөдлөх хөрөнгө, түрээст бизнесийн салбарт- 3.3% тус тус бий болсон. Шинээр бий болсон эдгээр ажлын байрнаас 70.0 % нь байнгын, 30.0 % нь түр ажлын байр эзэлж байна.

Ажилд зуучлагдсан ажилгүй иргэдийн 55.5 % нь эмэгтэйчүүд, 65.9 % нь 16-34 насныхан, 23.2% нь 35-44 насныхан, 10.9% нь 45-60 насны хүмүүс эзэлж байгаа ба ажилд зуучлуулагчдын 12.5 % нь төсөвт болон улсын үйлдвэрийн газар, 54.6 % нь хувийн хэвшлийн аж ахуйн нэгжид, 4.9 % нь хоршоонд, үлдсэн 28.0% нь хувиараа хөдөлмөр эрхэлж байна

Нийт 22200 ажилгүй иргэдийг мэргэжлийн сургалтанд хамруулсан ба эдгээрээс 17662 нь мэргэжлийн сургалтын төвд, 639 нь шавь сургалтанд, 152 нь үйлдвэр дээрх сургалтад, тус тус хамрагдсан ба хамгийн олон хүн хамрагдсан мэргэжлийн төрөл нь оёдол эсгүүрийн чиглэл болсон ба уг сургалтад 1194 хүн хамрагдсан.

2004 онд 18711 ажилгүй иргэдийг нийтийг хамарсан ажилд хамруулж, 610.0 сая төгрөгийг хөдөлмөр эрхлэхийг дэмжих сангаас зарцуулсан. Энэ ажилд хамрагдагсдын 90 гаруй хувь нь хөдөлмөр эрхлэлтийн албанд бүртгэлтэй ажилгүйчүүд хамрагдсан болно.


Жижиг зээлд нийт 3029 иргэн хамрагдаж, 2865.8 сая төгрөгийн зээл авч 6494 ажлын байр шинээр бий болгосон .Нийт зээл авсан иргэдийн 58.9 % нь хувиараа хөдөлмөр эрхлэлтэд; 7.0 % нь нөхөрлөл, хоршооллын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа болно.

Ажил олгогчийг дэмжих арга хэмжээнд нийт 1347 иргэн, аж ахуйн нэгж байгууллага хамрагдан 221.7 сая төгрөгийн нөхөн олговор олгосон.

Нийгмийн үйлчилгээний салбарууд дээрх байдлаар үйл ажиллагаа явуулж байгаа боловч Монгол улсад ажилгүйдэл, ядуурал газар авсаар байна.

Монгол улс 2002 оны байдлаар хүний хөгжлийн индексээр дэлхийн 175 орноос 117-д орсон байна. Хүний хөгжлийн индексийн дэлхийн дундаж 2001 онд 0.729 байсан бол манай улсынх 0.668 байв. Харин бага орлогтой улс орнуудын хүний хөгжлийн индекс 0.557 байгаа юм (Б.Энхтүвшин, Б.Батмөнх, 2004. 7-р тал).

График 7. Хүний хөгжлийн индекс 2002 он



Эх сурвалж: Б.Энхтүвшин, Б.Батмөнх, 2005. 7-р тал

Монгол Улсыг зүүн өмнөд Азийн хөгжиж буй зарим орнуудын нийгэм, эдийн засаг, хүний хөгжлийн үзүүлэлтүүдийг харьцуулан үзэхэд эдгээр 23 улсын хувьд харьцангуй боломжийн дундаж байдалтай байна. Энэ дурьдсан мэдээлэл нь 2000-2001 оны мэдээлэл бөгөөд түүнээс хойш, өнөөдрийг хүртэл улс орнуудын нөхцөл байдал өөрчлөгдөн нь мэдээж юм. Тухайлбал Монгол улсын нэг хүнд оногдох дотоодын нийт бүтээгдэхүүн 2003 оны байдлаар 511.9 ам долларт хүрч 2000 оны түвшингээс даруй 29.3 хувиар өсжээ.

Хүснэгт. Зүүн өмнөд Азийн улс орнуудын нийгэм, эдийн засаг, хүн амын зарим үзүүлэлтүүд 2000/2001

Улс орон	Хүн ам		Нялхасын эндэгдлийн хувь (0/000) 1995-2000	Дундаж нас наслалт (жилээр)		Хотын хүн ам (%) 2000	Нэг хүнд оногдох ҮНБ		бичиг үсгийн түвшин 15+ 2000	
	Бүгд (000) 2000	Дундаж өсөлт 1990-2000		Дундаж нас наслалт (жилээр)			Дундаж өсөлт 1990-2000	2000 он USD	бичиг үсгийн түвшин 15+ 2000	
				Бүгд	Эм				Бүгд	Эм
Афганистан	21 765	4.6	165	43	43	21.9	-	-	-	-
Бангладеш	137 439	2.2	79	58	58	25.0	4.6	370	40.0	30.2
Бутан	2 085	2.1	63	61	62	7.1	5.7	590	-	-
Бруней	328	2.4	10	75	78	72.2	-	-	91.5	88.1
Камбоджи	13 104	3.1	83	56	59	16.1	11.0	260	68.0	57.2
Хятад	1 275 133	1.0	41	70	70	35.8	11.6	840	85.2	77.9
БНАСАУ	22 268	1.1	45	63	66	60.2	-	-	-	-
Энэтхэг	1 800 937	1.8	73	62	63	27.7	3.8	450	57.2	45.4
Индонези	212 092	1.5	48	66	67	41.0	2.7	570	88.8	81.9
Иран	70 330	1.8	44	68	69	64.0	-	1680	76.0	68.9
Лаос	5 279	2.4	97	54	54	19.3	-	290	64.8	53.4
Макао	444	1.8	-	-	-	98.8	6.7	14580	93.8	91.0
Малайзи	22 218	2.2	12	75	73	57.4	6.9	3380	87.4	83.4
Малдивес	291	3.0	46	65	64	27.6	15.5	1960	96.9	96.8
Мянмар	47 749	1.6	92	56	58	27.7	-	-	84.7	80.5
Непал	23 043	2.4	83	57	57	11.8	4.4	240	41.7	24.0
Пакистан	141 256	2.5	95	59	59	33.1	4.3	440	34.2	27.9
Филлипин	75 653	2.1	34	69	71	58.6	6.0	1040	94.9	94.8
Шри ланк	18 924	1.1	23	72	75	22.8	7.4	850	91.6	89.0
Тайланд	62 806	1.3	25	70	73	19.8	3.6	2000	95.5	93.9
Зүүн Тимор	737	-	-	-	-	7.5	-	-	-	-
Вьетнам	78 137	1.7	40	68	70	24.1	-	390	92.5	90.7
Монгол	2 374	1.5	29.5	63.4	66.6	56.6	1.5	396	97.8	97.5

Эх сурвалж: UIS, 2003.

Монгол улсад 3 дахь удаагаа ҮСГ амьжиргааны түвшний судалгааг явуулж, үр дүнг гаргаад байна. Судалгаа нь Монгол улсын хүн амын ядуурлын байдлыг шинэчилсэн тогтолцоонуудыг бүс нутаг болон байршлаар гаргаж, ядуу хүн амыг ядуу бус хүн амаас ялгах үндсэн шинж чанарыг тодорхойлсон, ядуурлын дүр төрхийг илэрхийлэхэд чиглэгджээ. Өрхийн орлого, зарлага амьжиргааны түвшний судалгаа нь 2002 оны 02 сараас 2003 оны 07 сарыг хүртэл хугацаанд түүвэрлэлтийн аргаар Улаанбаатар хот, 21 аймагт нийт 11232 өрхийг хамруулж явуулсан байна. Уг судалгаагаар Монгол улсын хүн амын 36.1 хувь нь ядуу байна гэсэн дүн гарчээ. Судалгаа нь ядуурлыг боловсролын түвшин, эрүүл мэнд, ажил эрхлэлт, нийгмийн хамгаалал, халамж, өрхийн ам бүлийн бүтэц, өрхийн тэргүүлэгчийн шинж байдал, хөрөнгө, өрхийн сууцны байдлаар гаргахын зэрэгцээ, ядуурлыг улирлын хэлбэлзэлтэй болохыг тодорхойлжээ. Эндээс манай ажлын хэсэг ядуурлын талаар анхдагч судалгааг явуулаагүй бөгөөд харин улсын хэмжээнд төрийн болон төрийн бус байгууллагын энэ талаарх судалгааны материалыг хоёрдогч эх сурвалж болгон ашиглав. Судалгааны дүнг хүснэгтээр үзүүлбэл:

Хүснэгт. Ядуурлын түвшин 2003

	Улсын дундаж	Баруун	Хангай	Төв	Зүүн	Улаанбаатар
Ядуурлын хамралтын хүрээ	36.1	51.1	38.7	34.4	34.5	27.3
Ядуурлын гүнзгийрэлт	11.0	14.6	12.3	10.1	12.4	8.1
Ядуурлын мэдрэмж	4.7	5.7	5.2	4.3	6.6	3.3

Эх сурвалж: UIS, 2004. Өрхийн орлого, зарлагын судалгаа /2002-2003/ Улаанбаатар

Ядуурлыг багасгах талаар хүч чармайлт тавьж байгаа хэдий ч түүний хувь хэмжээ олигтой буурахгүй хэвээр байна. Албан ёсны тоо баримтаас үзэхэд нийт хүн амын гуравны нэг орчим нь ядуу амьдарч байна. Энэ нь хүнсний болон бусад наад захын хэрэгцээг хангаж чадахгүй байдлаар илэрдэг. Мөн олон хүн ядуурлын ирмэг дээр байна. Аль ч үзүүлэлтийг авч үзсэн ядуурлыг бууруулах асуудал нь үнэхээр улс орны өмнө тулгарсан чухал сорилт болжээ.

Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд бүс нутгаар

	Улсын дундаж	Баруун	Хангай	Төв	Зүүн	Улаанбаатар
Ядуурлын хамралтын хүрээ	36.1 /1.4/	51.1 /3.5	38.7 /2.7/	34.4 /3.0/	34.5 /4.4/	27.3 /2.6/
Ядуурлын гүнзгийрэлт	11.0 /0.6/	14.6 /1.3/	12.3 /1.3/	10.1 /1.4/	12.4 /2.3/	8.1 /1.0/
Ядуурлын мэдрэмж	4.7 /0.3/	5.7 /0.7/	5.2 /0.7/	4.3 /0.8/	6.6 /1.6/	3.3 /0.5/
✓						
Тэмэлт үзүүлэлтүүд:						
Ядуурлын шугамаас доогуур хүн амын хувийн жин (%)	100.0	24.0	25.8	18.6	8.9	22.8
Ядуурлын шугамаас доогуур хүн амын тоо (мян.хүн)	894.0	214.4	230.5	166.3	79.1	203.8
Хүн амын хувийн жин (%)	100.0	17.0	24.1	19.5	9.3	30.2
Хүн амын тоо (мян. хүн)	2,475.4	419.8	596.1	483.4	229.0	747.3
Өрхийн ам бүийн тоо	4.3	4.6	4.1	4.1	4.4	4.4
Хүн ам зүйн ачаалал (%)	43.3	46.7	43.0	44.3	45.2	40.6
Хүүхдийн тоо (% өрхийн ам бүлд)	31.2	37.1	31.2	29.7	36.0	27.5
Өрхийн тэргүүлэгчийн нас	44.5	42.5	43.1	44.7	41.9	47.3
Эрэгтэй тэргүүлэгчтэй өрх (%)	82.5	91.6	85.2	79.4	85.7	76.6
Хотжилт (%)	55.4	34.8	31.3	40.6	42.0	100.0

Танамж: 2002 оны нийт хүн амын тоо Хүн ам, орон сууцны 2000 оны тооллогын дүнд үндэслэсэн. Судалгааны түүвэрлэлтийн стандарт алдааг хаалтанд тэмдэглэсэн.


Эх сурвалж: ӨОЗАТС 2002/03.

Шилжилтийн эхний жилүүдэд үндэсний орлого огцом буурч, ажилгүйдэл ихсэж, инфляци огцом өсч, нийгмийн салбарын санхүүжилт буурснаар ядуурал эрс нэмэгдсэн юм.

Ядуурлын судалгааны нэгж, нийгмийн хөгжлийн төвөөс явуулсан “Ядуу өрхийн амжиргаанд үзүүлэх ахуйн хэрэглээний үнийн нөлөөлөл” гэсэн судалгааны дүнгээс харвал/нийт 200 өрх оролцсон/:

- Өрх дунджаар 4 гишүүнтэй байна. Өрхийн гишүүдийн 39.7 хувь нь 18-аас доош насныхан байна.
- Судалгаанд 100 гаруй өрх толгойлсон эмэгтэйчүүд бүхий өрх хамрагдсаны ихэнх нь нэн ядуу өрхүүд байна.
- Өрхийн хөдөлмөрийн насны гишүүдийн 6.5 хувь нь төсвийн байгууллагад, 10.3 хувь нь хувийн хэвшлийн байгууллагад, 2.6 хувь нь хувиараа, 13.2 хувь нь ажилгүй, 11.3 хувь нь тэтгэвэрт тэтгэмж авагч байв.
- Судалгаанд оролцсон нийт өрхийн гишүүдийн 4.7 хувь нь боловсролгүй, 11.5 хувь нь бага, 30.9 хувь нь бүрэн бус дунд, 29.9 хувь нь бүрэн дунд, 4.7 хувь нь мэргэжлийн, 5.4 хувь нь дээд боловсролтой.

Оролцооны болон кейсийн судалгаагаар өрхийн гишүүдийн өвчлөл, хөдөлмөрийн чадвараа алдах, төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй байдал нь өрхийн амжиргаанд ихээхэн сөргөөр нөлөөлж байна.



Дээрх судалгааны үр дүнд **ядуу өрхийг тодорхойлох үзүүлэлтийг дараах байдлаар гаргасан байна.**

Өрх толгойлсон эмэгтэйчүүдийн бүлэг	Өндөр настны бүлэг	Залуучуудын бүлэг
Хүүхдүүд нь сургууль завсардсан	Тэжээх үр хүүхэдгүй ганц бие хүмүүс	Өрхийн гишүүд ажилгүй байх
Өрхийн орлого амжиргааны баталгаажих түвшингээс доогуур байх	Үр хүүхэд нь ажилгүй байх	Боловсролын түвшин бага боловсрол эзэмших болмжгүй байх
Орлогоо өсгөх боломжгүй байх	Тэтгэвэр бага ажил хийх боломжгүй байх	Гэр орны орчин нөхцөл тааруу, хүнд байх
Залхуу, арчаагүй, архичин байх	Өндөр настан хэт олон хүнийг тэжээдэг байх	Цахилгаан, халуун хүйтэн усгүй байх
Олон хүүхэдтэй, өрх толгойлсон байх	Өрхийн тэргүүлэгч архичин байх	Өрхийн орлого зайлшгүй зардалд хүрэлцдэггүй байх
Өрхийн гишүүд хүнд өвчин туссан байх		Өвчтэй, группт орсон, хөгжлийн бэрхшээлтэй гишүүд байх
Харьяалалгүй байх		
Өрийн гэр оронгүй байх		

Хүснэгт. Ядуурлын түвшин 2003

	Улсын дундаж	Баруун	Хангай	Төв	Зүүн	Улаанбаатар
Ядуурлын хамралтын хүрээ	36.1	51.1	38.7	34.4	34.5	27.3
Ядуурлын гүнзгийрэлт	11.0	14.6	12.3	10.1	12.4	8.1
Ядуурлын мэдрэмж	4.7	5.7	5.2	4.3	6.6	3.3

Эх сурвалж: UIS, 2004. Өрхийн орлого, зарлагын судалгаа /2002-2003/
Улаанбаатар

Ядуурлыг багасгах талаар хүч чармайлт тавьж байгаа хэдий ч түүний хувь хэмжээ олигтой буурахгүй хэвээр байна. Албан ёсны тоо баримтаас үзэхэд нийт хүн амын гуравны нэг орчим нь ядуу амьдарч байна. Энэ нь хүнсний болон бусад наад захын хэрэгцээг хангаж чадахгүй байдлаар илэрдэг. Мөн олон хүн ядуурлын ирмэг дээр байна. Аль ч үзүүлэлтийг авч үзсэн ядуурлыг бууруулах асуудал нь үнэхээр улс орны өмнө тулгарсан чухал сорилт болжээ.

Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, бүс нутгаар

	Улсын дундаж	Баруун	Хангай	Төв	Зүүн	Улаанбаатар
Ядуурлын хамралтын хүрээ	36.1 /1.4/	51.1 /3.5/	38.7 /2.7/	34.4 /3.0/	34.5 /4.4/	27.3 /2.6/
Ядуурлын гүнзгийрэлт	11.0 /0.6/	14.6 /1.3/	12.3 /1.3/	10.1 /1.4/	12.4 /2.3/	8.1 /1.0/
Ядуурлын мэдрэмж	4.7 /0.3/	5.7 /0.7/	5.2 /0.7/	4.3 /0.8/	6.6 /1.6/	3.3 /0.5/
Нэмэлт үзүүлэлтүүд:						
Ядуурлын шугамаас доогуур хүн амын хувийн жин (%)	100.0	24.0	25.8	18.6	8.9	22.8
Ядуурлын шугамаас доогуур хүн амын тоо (мян.хүн)	894.0	214.4	230.5	166.3	79.1	203.8
Хүн амын хувийн жин (%)	100.0	17.0	24.1	19.5	9.3	30.2
Хүн амын тоо (мян. хүн)	2,475.4	419.8	596.1	483.4	229.0	747.3
Өрхийн ам бүийн тоо	4.3	4.6	4.1	4.1	4.4	4.4
Хүн ам зүйн ачаалал (%)	43.3	46.7	43.0	44.3	45.2	40.6
Хүүхдийн тоо (% өрхийн ам бүлд)	31.2	37.1	31.2	29.7	36.0	27.5
Өрхийн тэргүүлэгчийн нас	44.5	42.5	43.1	44.7	41.9	47.3
Эрэгтэй тэргүүлэгчтэй өрх (%)	82.5	91.6	85.2	79.4	85.7	76.6
Хотжилт (%)	55.4	34.8	31.3	40.6	42.0	100.0

Санамж: 2002 оны нийт хүн амын тоо Хүн ам, орон сууцны 2000 оны тооллогын дүнд үндэслэсэн. Судалгааны түүвэрлэлтийн стандарт алдааг хаалтанд тэмдэглэсэн.

Эх сурвалж: ӨОЗАТС 2002/03.

Шилжилтийн эхний жилүүдэд үндэсний орлого огцом буурч, ажилгүйдэл ихсэж, инфляци огцом өсч, нийгмийн салбарын санхүүжилт буурснаар ядуурал эрс нэмэгдсэн юм.

Эндээс “ядуу хүн”, “ядуу” гэсэн ойлголтыг өрхөөс салгангид авч үзэх боломжгүй гэдэг нь харагдаж байна.

Сүүлийн арван жилд ядуурлын тархалт, тэгш бус байдал улам нэмэгдэж, ядуурал бодитой буурсангүй. Энэ хандлагыг зогсоохгүй бол 2015 он гэхэд ядруулын түвшинг хоёр дахин бууруулах Мянганы хөгжлийн зорилт /МХЗ/ биелэхгүйд хүрнэ.

Ядуурал гэдэг нь зөвхөн орлого буюу хэрэглээ хангалтгүй байх гэсэн үг биш юм. Ядуурлыг чанарын талаас нь үнэлэх зорилгоор оролцооны арга хэрэглэн амьжиргааны түвшний судалгааг 2000 онд Дэлхийн банк, бусад хандивлагчдын тусламжтайгаар явуулсан. Судалгаанаас харахад ажилгүйдэл, гэр бүлийн хүчирхийлэл болон архидалтын улмаас хувь хүний өөртөө итгэх итгэл алдарч, өөрөө өөрийгөө үл хүндлэх байдал гарч байгаа нь ажиглагджээ.

Түүнчлэн ядуурал нь ажилгүйдэл, боловсрол, эрүүл мэнд, түүний дотор нөхөн үржихүйн эрүүл мэндийн үйлчилгээний түвшин доогуур байгаатай шууд холбоотой.

Өрхийн судалгаанаас үзэхэд нэн ядуу иргэдийн 1/3 нь ажилгүй байгаа нь ядуу бус хэсгийнхэнтэй харьцуулахад 3 дахин өндөр байна. Ажилгүйдэл нь өөрийгөө дорд үзэх, сэтгэлээр унах, архинд орох, гэр бүлийн хүчирхийлэл болон гэмт хэрэгт өртөхөд нөлөөлдөг учраас нийгмийн ихээхэн хор хөнөөлтэй. Тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ маш бага байгаа ч тэдгээрээс нэн ядуу айл өрхийн амьдрал ихээхэн хамаарч байгаа нь бас нэг онцлог юм. Тухайлбал нэн ядуу өрхийн орлогод тэтгэвэр, тэтгэмжийн эзлэх хувь ядуу бус өрхтэй харьцуулахад хотод 2.4 дахин, хөдөөд 2 дахин өндөр байна.

Шилжилтийн үеийн үзүүлэлтүүдээс шинээр авч үзэх шаардлагатай болсон асуудал нь ядуурлыг бууруулах гадаадын зээл, тусламж болон төслийн хөрөнгийн талаарх асуудал юм.

ГАДААДЫН БУЦАЛТГҮЙ ТУСЛАМЖААР ХЭРЭГЖИЖ БУЙ ТӨСЛҮҮДИЙН ЖАГСААЛТ

2004 оны эхний хагас жилийн байдлаар

Төслийн нэр	Эхлэх он	Дуусах он	Үргэлжлэх хугацаа /жилээр/	Хандивлагч орон, байгууллага	Нийт төсөв/мян.ам. доллар/	Үүнээс ашигласан /мян.ам. доллар/
Ядуурлыг бууруулах-нийгмийн хамгааллын сүлжээ	1997	2004	8	АХБ	985	874
Нийгмийн хамгааллын өртөгийн боловсронгуй	2002	2004	3	АХБ	600	434
Ажил эрхлэх боломжийг нэмэгдүүлэх	2003	2004	2	АХБ	1000	373,5
Хэрэгжилтийг сайжруулах	1999	2004	6	Чадавхи-21	300	300
Төрийн албан хаагчдын богино хугацааны мэргэжил дээшлүүлэх	2003	2005	3	Чех	303	303
Солилцооны хөтөлбөр						
Тахир дутуу иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх	2002	2005	4	Япон	679,5	669
Ядуурлыг бууруулах	2001	2005	5	Швед	1537	1114

судалгаа ба ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх						
Ядуурлын судалгаа ба ажил эрхлэлтийг дэмжих төсөл	2003	2004	2	НҮБХХ	142	87
Хотын ядуурлыг бууруулах хөтөбөрийг боловсруулахад дэмжлэг үзүүлэх	2003	2004	2	НҮБХХ	200	78,27
Ядуу хүмүүсийн амьдрах орчныг сайжруулах/ шинэ төсөл/	2003	2005	3	АХБ	2200	0
Хүн ам, жендер, хөгжлийн хүчин зүйлүүдийг үндэсний төлөвлөгөө, хөтөлбөр, боловсруулахад бодлогод нэгтгэн уялдуулах чадавхийг дээшлүүлэх	2002	2006	5	НҮБХАС	314	156
Судалгаа, шинжилгээ, төлөвлөгөө	2004	2005	2	НҮБХС	34	4,25
Өсвөр үеийнхний эрхийг хамгаалах	2004	2005	2	НҮБХС	47,98	25,16
Нийгэм хамгаалалыг бэхжүүлэх	2004	2005	2	НҮБХС	80	25,44
Тогтвортой амжиргаанд иргэд, олон нийтийг татан оролцуулах	2003	2006	4	Дэлхийн банк	520	440
Гудамжны хүүхдийг нийгмийн амьдралд татан оролцуулах	2003	2005	3	Дэлхийн банк	710	550
Хүүхдийн хөгжил хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөрийн төлөвлөлт	2004	2005	2	НҮБХС	14	0

Эх сурвалж: НХХЯ-ны дотоод мэдээлэл.

Хэдийгээр дээрх байдлаар олон улсын гадаад болон дотоодын хөрөнгө оруулалт, ядуурал хэмээх "ёроолгүй ангал" руу хийгдэж байгаа боловч нийт хүн амын дунд эзлэх ядуу хүмүүсийн хувь хэмжээ буурахгүй байгаа нь түүний үр дүнг эргэн харах, өөрчлөлт хийх шардлагатай байгааг харуулж байна.

Ядуурлын талаарх хамгийн өргөн хэрэглэгддэг тодорхойлолт бол эд зүйлс буюу **орлоготой холбоотойгоор орлогын ядуурал** гэж нэрийдэн тухайн улсад мөрдөгдөж байгаа амьжиргааны доод түвшингээс / наад захын хэрэглээ /доогуур амьжиргаа залгуулахыг хэлдэг. Энэ аргаар ядуурлыг авч үзэх нь тухайн хүний аж байдал сайжрах талаас бус эд зүйлс, худалдаж авах орлогын тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд илүү түлхэцтэй болно.

Нөгөө талаар ядуурлыг сайн сайхан аж байдалд хүрэх талаас бус эцсийн зорилгыг илүүтэй чухалчлах буюу **хүний өөрийн чадавхи талаас авч үзэх** хоёр дахь аргачлал байдаг. Чадавхи гэдэг нь уншиж бичих, урт удаан эрүүл саруул амьдрах, чөлөөтэй шилжин суух, нийгмийн амьдралд идэвхтэй оролцох зэргийг багтаасан ойлголт байна. Чадавхийн ядуурал нь илүү өргөн ойлголт учраас НҮБХХ /1997/ Хүний Ядуурлын Индекс хэмээх үзүүлэлтийг тооцоолж гаргах болжээ.

Ядуурлыг хэмжих гуравдах арга бол **нийгмийн доройтлоор хэмжих түгээмэл** арга ба нийгмийн түвшингээр тодорхойлно. Хөрөнгийн хязгаарлагдмал нөөц бүхий засгийн газар ядуурлыг бууруулахын тулд ямар хэмжүүрээр хэмжих нь зохистой вэ гэсэн асуулт гарах ба эдгээр хэмжүүрийг сонгохдоо нэгийг нөгөөгөөр нь орлуулах байдлаар бус нэг нь нөгөөгөө нөхөх байдлаар авч үзэх нь илүү зохистой гэж үздэг байна. Манайд ихэнхдээ 1-р аргын хүрээнд ядуурлын түвшинг тодорхойлж тусламж үйлчилгээг үзүүлж байгаа нь ядуурлаас гарах замыг эрэлхийлэх бус нийгэмд бүх бурууг тохож, "бэлэн мөнгө, эд хөрөнгө" хүртэх сонирхлыг нийтийн дунд бий болгож байна.

Өмч хувьчлал, төрийн албаны шинэчлэлээр ажилчин, албан хаагчдын нилээд хэсэг нь хувийн хэвшил, албан бус сектор луу, малчид тариаланчид үйлдвэрлэл, хөдөлмөрийн зохион байгуулалттай хэлбэрээс өрхийн аж ахуйн үйлдвэрлэлд шилжсэн, шилжилтийн үеийн бүтцийн өөрчлөлт нь улмаар бүртгэлтэй болон бүртгэлгүй ажилгүйчүүдийг бий болох нөхцлийг бүрдүүлэн улмаар ядуурлыг бий болгох үндсэн нөхцлийг бүрдүүлсэн гэж үзэж болно. Монгол Улсад хөдөлмөрийн насны хөдөлмөр эрхлэх боломж бүхий 926 мянган иргэд байдаг ба үүнээс хөдөлмөр эрхлээгүй албан болон албан бус секторт ажиллаж байгаа 220 мянган хүн ажилгүй байна гэсэн судалгаа байна.

Гэтэл хөдөлмөр эрхлэлтийн орон нутгийн албанд бүртгэлтэй ажилгүй иргэний тоо 50 орчим мянга байгаа ба 170-аад мянган хүн бүртгэлгүй ажилгүйчүүдэд хамаардаг ба эдгээрээс жилд 35-40 мянган хүнийг ажлын байраар хангадаг ба энэ нь нийт ажилгүй хүмүүсээс цөөхөн хувийг л эзэлдэг.

Бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо, ажилгүйдлийн түвшинг хүйсээр авч үзвэл:


Ажилгүйчүүдийн тоо	Бүгд	Эмэгтэй	Эрэгтэй
1992	54.0	29.0	25.0
1995	45.1	23.6	21.5
2000	38.6	20.7	17.9
2001	40.3	21.9	18.4
2002	30.9	16.8	14.1
2. Ажилгүйдлийн түвшин, хувиар			
2000	4.6	5.0	4.5
2001	4.6	5.1	4.2
2002	3.4	3.8	3.1

Эх сурвалж: Монгол Улсын статистикийн эмхтгэл, ҮСГ, 1995, 2000, 2003

Дээрх тоон үзүүлэлтээс харахад ажилгүйчүүдийн тоо өмнөх үеэс /1992-1995/ харьцангуй буурсан боловч одоо үед /2004/ оны байдлаар 50 орчим мянган хүн байгаа нь хангалтай сайн үзүүлэлт биш юм.

Ажилгүйдлийг бууруулах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хүрээнд төрөөс бодлогын шинжтэй дараах хөтөлбөрүүдийг батлан гаргаж дагаж хэрэгжүүлж байна. Тухайлбал:

- МУ-ын Засгийн газрын мөрийн хөтөлбөрийн нийгмийн бодлогын хүрээнд ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, нийгмийн хамгааллыг сайжруулах зорилт
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих Үндэсний хөтөлбөр



Ажилгүйдэл. Монгол Улсын хувьд ажилгүй иргэдэд ажилд зуучлах, мэргэжил эзэмшүүлэх сургалтад хамруулан мэргэжил эзэмшүүлэх мөн жижиг зээл олгох болон ажлын байраар хангах ажлыг Хөдөлмөр Халамжийн Үйлчилгээний Газрын харьяа орон нутгийн хөдөлмөр халамжийн үйлчилгээний хэлтсийн хөдөлмөр эрхлэлтийн алба эрхлэн хариуцдаг ба энэ нь ажил хайгч аж ахуйн нэгж байгууллага болон ажил хайгч ажилтан хоёрыг холбох үүргийг гүйцэтгэдэг.

Хэдийгээр ажилгүй иргэдэд ажилгүйдлийн болон ажлаас халагдсны тэтгэмж олгон мэргэжил эзэмшүүлэн сургалтад хамруулж, ажлын байраар хангах ажлуудыг гүйцэтгэдэг ч Улаанбаатар хотын Баянгол, Баянзүрх, Сонгинохайрхан, Сүхбаатар дүүрэг, Орхон, Ховд аймгийн хөдөлмөрийн насны нийт 174 иргэнээс авсан судалгаагаар "ажилгүйдэл их байгаагийн учир шалтгаан" гэсэн асуултад

- Ажлын байр байхгүйгээс 32,4%
- Мэргэжил боловсрол эзэмшээгүйгээс 18,9%
- Ажилд тавих шаардлага өндрөөс 7,4%
- Цалин хөлс амьдралд хүрэхгүйгээс 19,2%
- Танил тал байхгүйгээс 16,5%
- Хаанаас ажлын байр олохоо мэдэхгүйгээс 5,4%

Ажилгүйдэл их байгаа шалтгааныг хөдөөгийн хүн амын хувьд ихэнхдээ мэргэжил, боловсрол эзэмшээгүй, танил тал байхгүйгээс болдог гэж хариулсан бол хотын хүмүүсийн хувьд ажлын байр байхгүй, ажлын шаардлага өндөр, цалин хөлс муу гэж хариулсан байна.

Судалгаанд хамрагдсан нийт иргэдийн 98 буюу 56,3% нь эмэгтэй, 76 буюу 43,7% нь эрэгтэй 72 буюу 41,3% нь ажил эрхэлдэг үлдсэн 102 буюу 58,6% нь тодорхой эрхэлсэн ажилгүй иргэн байлаа.

Эдгээр иргэдийг насны ангилалаар авч үзвэл 18-35 насны иргэн 111 буюу 63,7%, 36-45 насны иргэн 51 буюу 29,4%, мөн 46 дээш насны иргэн 12 буюу 6,9%-ийг эзэлж байлаа. Мөн нийт судалгаанд хамрагдсан 174 хүний 52,3% нь амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур, 44,8% нь дундаж, үлдсэн 2,8% нь дээгүүр орлоготой иргэд байлаа.

Дээрх судалгаанд хамрагдсан 174 хүнээс

Ядуурал байгаагийн шалтгаан, нөхцөл юу гэж үзэж байна вэ?

- Цалин орлого хүртээмж муу 29,5%
- Ам бүл дэхь хөдөлмөр эрхэлдэг хүний тоо цөөн 15,5%
- Орлого, цалингүй 21,8%
- Гэр бүлийн гишүүдийн тоо олон 7,2%

- Ажлын байр хүрэлцээгүй 22,2%
- Газар зүйн байршил 2,3%
- Байгалийн нөлөөлөл 1,4%

Ядуурлын шалтгаан нөхцөлийг хот хөдөөгийн хүн ам өөр өөрөөр үзэж байна. Хөдөөгийн иргэдийн хувьд газар зүйн байршил, байгалийн нөлөөлөл нь ядуурлын шалтгаан болдог хэмээн зарим нь хариулсан байхад хотын хүн амын хувьд ихэнх нь цалин, орлого хүртээмж муу, ажлын байр хүрэлцээгүй гэж хариулсан байна.

Ядуу гэсэн ойлголтыг хэрхэн тодорхойлох вэ?

- Орлого багатай амьдралын хүртээмж муу 45,8%
- Амьдралын түвшингээр нь 26,5%
- Олон хүүхэдтэй бодит орлогогүй 20,4%
- Бусад 7,2%

Бусад гэж хариулсан хүмүүсийн ихэнх нь хөдөлмөрийн чадваргүй залхуу арчаагүй хүмүүсийг ойлгоно гэж хариулсан байхад зарим нь дээрх 3-н хувилбар бүгд орно гэсэн байв.

Та ядуурлыг бууруулахад хэрэгжүүлж буй төсөл, бусад арга хэмжээнд хамрагдаж зээл тусламж авч байв уу?

- Тийм 12,6%
- Үгүй 87,4%
-

Тийм гэж хариулсан хүмүүсийн хувьд зээл авахад танил тал их хардаг, авсан зээл нь бага ямар ч нэмэр болоогүй гэж тайлбарласан байв.

Нийгмийн бодлогын тулгамдсан асуудлууд

Соёл, урлаг. Соёлын бодлогын хүрээнд дараах зүйлсийг хэрэгжүүлэх шаардлагатай бөгөөд боломж нөхцөл нь байгаа юм.

- Нийгмийн хямрал, элдэв нөхцөл шалтгааны улмаас монголын соёл устгах, бусад үндэстний соёлд уусан замхрах, өв уламжлал, ёс заншил алдрах, оюун санааны амьдрал ядууран доройтохоос бүх талаар сэрэмжлэх,
- Үндэсний соёлыг дэлхийн соёлын ололттой хослуулан хөгжүүлэх,
- Монголын эрт эдүгээгийн түүх, соёлын дурсгалт зүйлс, сан хөмрөгийг үндэсний эрхэм баялаг гэж үзэж төрийн хамгаалалтад байлгах,
- Монголын олон овогтны өв соёл, түүх, ёс заншлыг адил тэгш, хүндэтгэн үзэж хадгалан баяжуулж хөгжүүлэх нөхцөл бололцоог хангах
- Иргэдийн сэтгэлгээний болон бүтээн туурвих, үр шимийг нь хүртэх эрх, эрх чөлөөг баталгаатай хангах, авьяас чадвараа илрүүлж, хөгжүүлэхэд бүх талын дэмжлэг үзүүлэх
- Соёлын үнэт зүйлийг бүтээн туурвигч, өвлөн хадгалагчийг төрийн ивээл, халамжид байлгах,
- Уран бүтээлчид үзэл бодол, арга барил, урсгал чиглэл, дэг сургуулиа чөлөөтэй сонгож хэрэглэхийг дэмжих
- Уран бүтээлчид сайн дураараа мэргэжлийн эвлэл, холбоо, нийгэмлэг байгуулж, үр өгөөжтэй соёлын үйл ажиллагаа явуулахыг дэмжих
- Соёлын салбарт өмчийн олон хэлбэр, зах зээлийн шударга чөлөөт өрсөлдөөнийг бий болгон үр ашигтай гадаад харилцааг хөгжүүлэх
- Монгол улсын төр засгаас соёл, урлагын салбарт тэр дундаа хөдөө орон нутгийн соёлын байгууллагуудын үйл ажиллагаанд хөрөнгө мөнгө, төсвийн санхүүжилтийг хангалттайгаар төсөвлөх
- Хөдөө орон нутаг дахь соёлын байгууллагуудын нөхцөл байдлыг сайжруулах
- Ард иргэдийн соёлын талаарх боловсролын асуудлыг сайжруулахад анхаарах /бага, дунд боловсролын салбарт/
- Монгол улсын соёлын байгууллагуудын үйл ажиллагааг сайжруулахад оновчтой маркетинг, менежментийн бодлогыг оновчтойгоор боловсруулах

Эрүүл мэнд. Өнөөгийн байдлаар улсын эрүүл мэндийн салбарын үйл ажиллагаанд тулгарч байгаа хүндрэл бэрхшээлүүдийн талаар дурьдвал:

- Улсын эрүүл мэндийн салбарт ажиллагсдын цалин бага, тэдний нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд төсөв хөрөнгө хүрэлцэхгүй байх, ажлын нөхцөл хүрэлцэхгүй байгаа /улсын хэмжээнд дундаж цалин 75.5 мянга байхад эрүүл мэндийн салбарт ажиллагсдын дундаж цалин 53.9 мянга байна. Менежментийн хувьчлалд хамрагдсан Баянзүрх дүүргийн эмчийн дундаж цалин 117.0 мянгад хүрсэн байна/
- Эмнэлэгийн ажилтнуудын ажлын чанарыг үнэлэх механизм оновчтой бус, илүү сайн чанартай, үр дүнтэй тусламж, үйлчилгээ үзүүлсний төлөө урамшууллын хөшүүрэг байдаггүй, ажил, мэргэжлийн онцлог, хүнд, хөнгөн ачаалал, чадвар харгалзахгүй адил цалин олгодог
- Эмнэлэгийн ажилтнууд шан харамж авч танил талда үйлчилдэг
- Эмнэлэгийн удирдлагын арга барил хоцрогдсон, дотоодын хяналт шалгалт хангалтгүй
- Эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд өрсөлдөөн хязгаарлагдмал байгаа
- Эрүүл мэндийн санхүүжилт хангалтгүйц, төлбөртэй үйлчилгээний системд шилжээгүй атлаа эмнэлэг бүр төлбөрт үйлчилгээ явуулдаг болсон
- Иргэдийн эрүүл мэндийн боловсрол, эрүүл мэндээ хамгаалуулах эрхээ хэрэгжүүлэх чадвар хангалтгүй
- Эмч, мэргэжилтнүүдийг бэлтгэдэг сургуулийн сургалт хангалтгүй байгаа. Сүүлийн жилүүдэд эмч нарыг бэлтгэдэг улс, хувийн сургууль, суралцагчид олширсон боловч, сургалтын чанар хангалтгүй, “диплом өвөртлөх” зорилго агуулдаг болсон
- Хөдөө орон нутагт болон нарийн мэргэжлийн гэмтэл согог, мэс засал, хавдар, халдварт өвчин, хүүхэд зэрэг мэргэжлийн эмч байнга дутагдалтай байдаг
- Оншилгоо, эмчилгээний орчин үеийн аппарат, багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж хангалтгүй

Нийгэм хамгаалалын салбар дахь тулгамдсан асуудал.

- Нийгмийн даатгалын тогтолцооны санхүүгийн чадавхийг сайжруулах. Энэ нь нийгмийн даатгалын сангийн алдагдлыг нөхөх, шимтгэл төлөхөөс зайлсхийдэг үзэгдлийг арилгах. Шимтгэл хураалтын сайжруулах нь тэтгэврийн сангийн чадавх бэхжихэд сайнаар нөлөөлөх бөгөөд шимтгэлийн хувь хэмжээг нэмэгдүүлэх шаардлагагүй болно.
- Даатгуулагчид олгож байгаа янз бүрийн тэтгэвэр, тэтгэмжүүд зохистой байгаа эсэхийг авч үзэх. Нийгэм хамгаалалын салбарт зохих төрлийн тэтгэвэр, тэтгэмжүүд олгогдож байгаа боловч түүний илрэх үр дүн нь өгөөж муутай байдаг. Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн 4 хүний 1 нь авдаг гэж үздэг боловч ядууралд нөлөөлж байгаа нөлөөлөл байдаггүй.
- Нийгмийн даатгалд даатгуулагчдын хамрагдалтыг сайжруулах. 2002 оны эцэст 350 000 малчид, 130 000 хувиараа хөдөлмөр эрхлэгчид байгаа нь Монгол улсын ажиллах хүчний 50 гаруй хувь болж байна. Хэдийгээр эдгээр иргэд одоогийн нийгмийн даатгалын тогтолцоонд сайн дураар хамрагдах эрхтэй боловч тэдний зөвхөн 4 хувь нь тэтгэврийн даатгалд хамрагддаг гэсэн тооцоо бий. Эдгээр иргэдийн дийлэнх нь нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авах нөхцөл, болзолын хангахгүй бөгөөд тэдэнд дэмжлэг болох цорын ганц эх үүсвэр нь маш бага хэмжээгээр олгох халамжийн тэтгэвэр л байх болно. Түүнчлэн халамжийн тэтгэвэр авах эрх үүсэх иргэдийн тоо эрс нэмэгдсэнээр Засгийн газар санхүүгийн томоохон бэрхшээлтэй тулгарах болно
- Улсын нийгмийн хамгаалалын зэрэгцээ хувийн салбарын хамгаалалын тогтолцоог бий болгох. Энэ нь ажилагсдад тэтгэврийн ашигтай бүтцийг сонгох боломжтой болгож тэтгэвэр нэмэгдүүлэхтэй холбогдон засгийн газарт ирдэг санхүүгийн ачааллыг багасгана.
- Нийгмийн хамгаалалын салбарт хяналтын хөшүүргийг хэрэгжүүлэх. Нийгмийн даатгалын байгууллага, татварын байгууллага, шаардлагатай бусад байгууллагуудын уялдаа холбоог сайжруулахын тулд нэгдсэн мэдээлэлийн тогтолцоог бий болгох нь тэтгэвэр, тэтгэмж зайлшгүй, шаардлага хангасан иргэдэд хүрч байх боломжийг бий болгоно.

Боловсрол. Боловсролын үндсэн зорилго нь хүний хөгжлийг бий болгож улмаар тэр нь нийгмийн хөгжлийн нэг хөдөлгөгч хүч болоход чиглэгддэг. Эдийн засгийн өсөлтөөр нийгмийг хөгжүүлэх үзэл баримтлалд зарим талаар засвар орж, хүн капиталын хөгжил нь нийгмийг хөгжүүлэх үндсэн нөхцөл болохыг судлаачид баталж байна.

Бага боловсролыг 6 наснаас нь эхлэн 6 жилийн хугацаанд эзэмшүүлэх нь дэлхий нийтийн хандлага болж байна. Монгол улс 2002 оны байдлаар албан ёсоор 8 наснаас бага боловсролд хамруулж буй дэлхий дээрх ганц орон, 4-өөс бага жилийн сургалттай 32 орны нэг болж байна.

Хүснэгт 4. Бага сургуульд элсэх нас, бага боловсролын сургалтын үргэлжлэх хугацаа (2002 он)

Улс орнууд	Элсэх албан ёсны нас					Сургалт үргэлжлэх хугацаа (жилээр)					
	4	5	6	7	8	3	4	5	6	7	8
Африк (52)			36	16			1	5	36	10	
Хойд америк (31)		15	12	4					21	10	
Өмнөд америк (12)			11	1			1	1	10		
Ази (50)		4	36	9	1	1	11	10	26	2	
Европи (43)	1	3	22	17		1	17	6	16	2	1
Далайн орнууд (17)		7	9	1				1	15	1	
Бүгд (205)	1	29	126	48	1	2	30	23	124	25	1
Монгол					+		+				

Эх сурвалж: UIS, 2004.

Бүрэн дунд боловсролын тухайд дэлхийн хөгжлийн хандлага 12 наснаас нь элсүүлж 6 жилийн хугацаанд бүрэн дунд боловсрол олгох чиглэлтэй байна. Монгол улсын тухайд дэлхийн энэ хандлага тохирч байгаа боловч ерөнхий боловсролын дунд сургуульд суралцах хугацаа 10 жил байгаа нь учир дутагдалтай болгож байгаа юм.

Хүснэгт 5. дунд сургуульд элсэх нас, дунд боловсрол (бүрэн бус ба бүрэн дунд боловсрол хамтдаа)-ын үргэлжлэх хугацаа (2002 он)

Улс орнууд	Элсэх албан ёсны нас					Сургалт үргэлжлэх хугацаа (жилээр)					
	10	11	12	13	14	4	5	6	7	8	9
Африк (52)	1	3	25	18	3		11	20	19		
Хойд америк (31)		5	22	4			16	13	2		
Өмнөд америк (12)		2	10				3	8	2		
Ази (50)	10	10	26	4		3	2	25	17	3	
Европи (43)	7	20	8	8		1	2	12	12	14	2
Далайн орнууд (17)		7	9	1			1	8	7	1	
Бүгд (205)	18	47	100	35	3	3	35	86	59	18	2
Монгол			+					+			

Эх сурвалж: UIS, 2004.

Олон улсын боловсролыг харьцуулан үздэг нэг үзүүлэлт бол сургуульд суралцах дундаж хугацаа юм. Манай орны тухайд дэлхийн дунджаас алимгүй бага байгаа боловч Азийн орнуудын дундажтай ойролцоо байна. Бүрэн дунд боловсролын түвшинд энэ үзүүлэлт учир дутагдалтай байгаа юм.

Хүснэгт 6, Сургалтын дундаж хугацаа (2001 он)

Улс орнууд	Сургуульд суралцах дундаж хугацаа (жилээр)					
	Багаас бүрэн дунд боловсрол хүртэл			Багаас дээд боловсрол хүртэл		
Африк (52)	7.6			7.8		
Хойд америк (31)	11.2			14.3		
Өмнөд америк (12)	12.1			13.7		
Ази (50)	8.9			9.9		
Европи (43)	12.4			15.4		
Далайн орнууд (17)	12.4			-		
Бүгд (205)	9.3			10.8		
Монгол	Бүгд	эр	эм	Бүгд	эр	эм
	8	8	9	10	9	11

Эх сурвалж: UIS, 2004

Аливаа улс орнуудын боловсролын тогтолцоо харилцан адилгүй байдаг тул түүнийг олон улсын түвшинд харьцуулан судлах зорилгоор ЮНЕСКО-гоос 1970-аад оноос эхлэн олон улсын боловсролын ангиллын стандарт тогтоох судалгаа хийж анх удаа 1975 онд Женевт болон олон улсын боловсролын чуулганаас "Олон улсын боловсролын ангилалын стандарт-ISCED"-ийг батлан гаргаж, 1978 онд Олон улсын боловсролын статистикийн стандартчлал боловсруулан гаргасан. Одоогийн мөрдөж байгаа Олон улсын боловсролын ангиллын стандарт ISCED -97-г 1997 оны 11 дүгээр сард ЮНЕСКО-гийн Ерөнхий чуулганы 29-р хуралдаанаар батлан гаргажээ.

Энэхүү ангиллын дагуу дээр нэр дурьдсан зүүн өмнөд Азийн улс орнуудын боловсролын тогтолцоог 2000-2001 оны хичээлийн жилийн байдлаар Монгол улсын боловсролын тогтолцоотой харьцуулан авч үзлээ. Нэр бүхий 23 улсаас БНАСАУ, Непал, Филиппин, Монгол улсууд 10 жилийн сургалтын тогтолцоотой байхад Бруней, Малайзи, Шри ланк улсууд 13 жилийн сургалттай байна. Мянмар, Факистан Шри ланк улсууд сургалтаа 5 наснаас, Хятад, Индонези улсууд 7 наснаас Монгол улс ганцаараа 8 наснаас бусад улсууд 6 наснаас эхэлж байна.

Хүснэгт 8. Боловсролын систем ISCED97-ийн дагуу 2000/2001

Улс орнууд	Нас																
	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	
Афганистан (6+3+3)12	0	0	0	0	1	1	1	1	1	1	2	2	2	3	3	3	
Бангладеш (5+5+2)12	0	0	0	1	1	1	1	1	1	2	2	2	2	3	3		
Бутан (7+2+2)11		0	0	1	1	1	1	1	1	1	2	2	3	3			
Бруней (6+3+4)13	0	0	0	1	1	1	1	1	1	2	2	2	3	3	3	3	
Камбоджи (6+3+3)12	0	0	0	1	1	1	1	1	1	2	2	2	3	3	3		
Хятад (5+3+3)11	0	0	0	0	1	1	1	1	1	2	2	2	3	3	3		
БНАСАУ (4+3+3)10		0	0	1	1	1	1	2	2	2	3	3	3				
Энэтхэг (5+3+4)12	0	0	0	1	1	1	1	1	2	2	2	3	3	3	3		
Индонези (6+3+3)12			0	0	1	1	1	1	1	1	2	2	2	3	3	3	
Иран (5+3+3)11			0	1	1	1	1	1	2	2	2	3	3	3			
Лаос (5+3+3)11	0	0	0	1	1	1	1	1	2	2	2	3	3	3			
Макао (6+3+3)11	0	0	0	1	1	1	1	1	1	2	2	2	3	3	3		
Малайзи (6+3+4)13		0	0	1	1	1	1	1	1	2	2	2	3	3	3	3	
Малдивес (7+3+2)12	0	0	0	1	1	1	1	1	1	1	2	2	2	3	3		
Мянмар (5+4+2)11	0	0	1	1	1	1	1	2	2	2	2	3	3				
Непал (5+3+2)10	0	0	0	1	1	1	1	1	2	2	2	3	3				
Факистан (5+3+4)12	0	0	1	1	1	1	1	2	2	2	3	3	3	3			
Филлипин (6+3+1)10			0	1	1	1	1	1	1	2	2	2	3				
Шри ланк (5+4+4)13		0	1	1	1	1	1	2	2	2	2	3	3	3	3		
Тайланд (6+3+3)12	0	0	0	1	1	1	1	1	1	2	2	2	3	3	3		
Зүүн Тимор (6+3+3)12		0	0	1	1	1	1	1	1	2	2	2	3	3	3		
Вьетнам (5+4+3)12	0	0	0	1	1	1	1	1	2	2	2	2	3	3	3		
Монгол (4+4+2)10	0	0	0	0	0	1	1	1	1	2	2	2	2	3	3		

Санал дүгнэлт

- *Нийгмийн бодлогын салбарт хэрэгжүүлж буй хөтөлбөр, стратеги, зорилтыг Үндсэн хуулийн болон салбарын эрх зүйн орчинтой уялдуулах*
 - *Нийгмийн бодлогын салбарын хамгийн тулгамдсан асуудлуудын нэг нь ажилгүйдэл ядуурал бөгөөд үүнийг болон бусад асуудлыг шийдвэрлэхэд боловсролын үүрэг нөлөөг нэмэгдүүлж боловсролоор дамжуулан нийгмийн бодлогын асуудлыг шийдвэрлэх стратеги хэрэгжүүлэх*
 - *Хүнийг нийгмийн бодлогын төвд тавьж асуудал тойрсон бус хүнд төвлөрсөн цогц бодлого хэрэгжүүлэх*
 - *Хүн нь нийгмийн үнэт капитал болохын хувьд нийгмийн хамгаалал хэмээх төрийн дархлаажуулалтын тэгш боломжоор хангагдах*
 - *Төр нь хүнээ, хүн нь хүнээ хүндэлсэн, төрөө дээдэлсэн, хууль зүйд захирагдсан, ирээдүйд баримжаалсан, оюунд шүтсэн, эрүүл аж төрөхөд чиглэсэн нийгмийн харилцаа, хэм хэмжээг хөгжлийн баримжаа болгох*
- Хүн амынхаа бичиг үсгийн чадварыг үнэн зөвөөр тодорхойлох нь улс орны хөгжлийн үйл явцад нэн чухал хэрэгтэй. Бичиг үсгийн түвшин тодорхойлдог олон улсын арга зүйг нэвтрүүлэх.
- Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтыг нэмэгдүүлэх нэг арга зам болох цэцэрлэгээс бусад сургалтын хэлбэрийг ашиглах хэрэгтэй боловч гэр бүлд нь эцэг эхээр нь дамжуулан сургах аргыг ашиглах, төв суурин газарт хувийн хэвшлийн цэцэрлэг байгуулахыг дэмжиж болохоор байна. Сургуульд элсэх нас 7, цаашдаа үүнээс ч буурах хандлагатай байгаа энэ үед сургуулийн өмнөх боловсролд хамрагдах насны хүрээ багасах юм. Энэ нь сургуулийн өмнөх боловсролын хамрагдалтыг нэмэгдүүлэх бас нэг боломж олгож байна. Цэцэрлэгийн сургалтын агуулгыг эргэж харах хэрэгтэй байгаа юм. Сургалтын үйл ажиллагаа эхлэх хамгийн тохиромжтой насыг судлаачид 4 нас хэмээн тогтоогоод байна. Нэг хэсэг хүүхэд хэл сурах, нөгөө хэсэг нь бичиж, уншиж сурах хэрэгцээтэй байхад зөвхөн бие бялдар, оюун санаа, үг хөгжил зэргээр хязгаарласан сургалт явуулж байгаа нь эцэг эхийн хүсэн хүлээж байгаа үр дүнтэй зөрчилдөж байна.
 - Сургуульд элсэх нас хэт орой, бага боловсролын үргэлжлэх хугацаа богино байгаа нь бага боловсролын нэг бэрхшээл болж байна. Нүүдэлчдийн онцлогт тохирсон бага насны хүүхдэд боловсролын үйлчилгээ үзүүлэх зохистой хэлбэрийг олох шаардлагатай болжээ. Бага боловсролын үйлчилгээг эцэг, эх гэр оронд нь ойртуулах дэлхийн хандлагыг харгалзан үзэж магадгүй бага боловсролын эхний 1-2 жилийн сургалтыг багийн түвшинд зохион байгуулж ч болох юм.
 - Бүрэн бус дунд боловсролын хамрагдалтыг нэмэгдүүлэх бүх хүүхэд суурь боловсрол эзэмшүүлэх төрийн бодлогыг хэрэгжүүлэхэд анхаарал хандуулах шаардлагатай. Энэ зорилгоор сургуулиас гаднах сургалтын бусад хэлбэр, зохион байгуулалтыг өргөн ашиглаж болох юм. Суурь боловсролын сургалтын агуулгын нэгэнт хүрсэн түвшинг бууруулахгүйгээр өнөөгийн нийгмийн эрэлтэд нийцсэн цогц чадвар олгох чиглэлд шинэчлэлт хийх хэрэгтэй.
 - Бүрэн дунд боловсролыг сонголтын олон хувилбарт боломжтой болгох шаардлагатай байна. Бүх хүүхдийг дараагийн шатны сургуульд элсэхэд бэлтгэхэд бус харин ажил амьдралд шаардлагатай дадал, чадвар олгох чиглэлээр түлхүү бэлтгэх нь өнөөгийн нэг онцлог болж байна. Бүрэн дунд боловсролын агуулга нь их, дээд сургуульд бэлтгэх зорилготой эрдэмжсэн нэг чиглэл, ажил хөдөлмөр, амьдралд бэлтгэх зорилготой практик нэг чиглэлтэй байдаг хандлагыг тооцож хэрэгжүүлж болох юм.
 - Мэргэжилтэй ажилтан бэлтгэх тогтолцоог бэхжүүлэхийн тулд одоогийн Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн нэр хүндийг өсгөх, чадавхийг нь бэхжүүлэх бодлого хэрэгжүүлж, нийт хүн амд зориулсан мэргэжлийн анхан шатны дадал олгох сургалтын төрөл бүрийн хэлбэрийг дэмжих нь зүйтэй.
 - Дээд боловсролын байгууллагын чанарыг дээшлүүлэх шаардлагатай байна. Үүний тулд коллеж, их дээд сургуульд тавих чанарын шаардлагыг нэмэгдүүлж,

тооны зохистой харьцааг бий болгох нь зүйтэй. Дэлхий нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн сургалтын хөтөлбөрийг эх орондоо нэвтрүүлэх чиглэлээрх санаачлагыг дэмжиж тухайлсан бодлого баримтлах шаардлагатай.

- Сургалтын агуулгад сонголтын боломжийг нэмэгдүүлэх хэрэгтэй. Мэдээллийн асар их далайгаас чухам юуг сонгож илүүтэй судлах нь суралцагч нэг бүрийн эрх мөн. Хичээл төвтэй сургалтаас асуудал төвтэй сургалтад шилжих хэрэгтэй.

- Сургалтын уламжлалт зохион байгуулалтын хэлбэрийг шинэчилж, орчин үеийн уян хатан, олон хувилбарт сургалтын зохион байгуулалтыг нэвтрүүлэх нь зүйтэй.

- Сурлагын үнэлгээний зорилго, хандлагыг шинэчилж, үнэлгээ нь суралцагчид дарамт болдоггүй, түүгээр ялгаварлан гадуурхах боломжгүй, сургалтыг дэмжих хэрэгсэл болгон өөрчлөх хэрэгтэй. Шалгалтыг хичээл нэг бүрээр тухайн үед мэдэж байгаа мэдлэгийг шалгах гэсэн хандлагаас татгалзаж, тухайн хүнд төлөвшсөн цогц чадамж буй хүн капиталын чанарыг хэмжих чиглэлээр хөгжүүлэх тулгамдсан асуудлуудын нэг юм.

- Багш суралцагчийн харилцааг хамтран ажиллагчийн харилцаанд хүртэл хөгжүүлэх нь шинэчлэлийн нэг гол хүчин зүйл мөн.

- Монгол Улсын төр, Засгийн Газраас хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажилгүйдэл, ядуурлыг бууруулахад чиглэсэн олон ажил явуулж буй боловч энэ салбарт зарцуулж буй хөрөнгийн хэмжээ нь ажилгүйдлийг багасгахад хангалттай их биш ба энэхүү бага хөрөнгийн зарцуулалт нь үр ашиг хүртээмж муутай байгаа учраас улсын төсвөөс энэ салбарт зарцуулах хувмарлах хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх

- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төрийн бодлогод цалин хөлс, урамшууллын асуудал хангалттай сайн тусгагдаагүй байгаа ба олон мянган хүн цалин хөлс багатай ажлын байранд хөдөлмөрлөх сонголт хийхгүй, гадаадад гарч ажиллах сонирхолтой байгаа нь шилжилтийн үеийн эдийн засгийн уналтын үед тохиосон инфляцийн асар их өсөлттэй цалин орлогыг уялдуулан индексжүүлж чадаагүйгээс бодит цалин бурч, хөдөлмөрийн үнэлэмж багасч, цалин хөлс нь амьжиргааны наад захын хэрэгцээг хангахад хүрэлцэхгүй, арилжаа наймаа эрхэлж, албан бус секторт ажиллахыг илүүд үзэж байгаа учраас ажиллагсдын цалин хөлсийг инфляцийн нөлөөнөөс хамгаалж индексжүүлж байх талаар бодлогын баримт бичигт тодорхой заалт хэлбэрээр тусгах

- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас зохион байгуулж байгаа мэргэжил олгох сургалтын хэлбэр нь хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд хийсэн судалгаанд тулгуурлаагүйгээс яг зах зээлд онц шаардлагатай ажил мэргэжлээр мэргэжилтэй ажилтан бэлтгэхэд чиглэгдээгүй, хугацааны хувьд богино, мөн түүний эцсийн үр дүнг тооцож үздэггүй учир ач холбогдол муутай болдог. Тиймээс хэрэгцээт мэргэжлийн сургалтыг явуулж сургалтын үр дүн нь тэднийг ажилгүйдлийн эгнээнээс хасахад чиглэгдэж байвал илүү үр дүнтэй байх болов уу?

- Боловсрол эзэмшээгүй, боловсрол муутайгаас тэдэнд ажлын байр олддоггүй /Ажлын байр олдсон ч цалин хөлс бага ажил олддог ба тухайлбал: манаач, ачигч, үйлчлэгч гэх мэт/ хөдөлмөрийн хөлсний үнэлгээ муу нь эргээд тэднийг ядууралд хүргэх үндэслэл болдог. Хэдийгээр дээд мэргэжил эзэмшсэн ч ажлын байранд тавих шалгуур өндөр учраас ажил эрхлэх боломжгүй /англи хэл, компьютерийн өндөр шаардлага тавьдаг нь тэдний эзэмшсэн мэргэжлийг харгалздаагүй/ Тиймээс боловсролын чанар, үзүүлэлтийг дээшлүүлэх.

- Монгол ажилчдын ажлын байранд гадаадаас ажиллах хүч ихээр оруулж ирж ажиллуулж байгаа ба нэг гадаадын ажилтанд ойролцоогоор сард 200 мянган төгрөг зарцуулдаг. /Ажлын байрны төлбөрт нэг ажилтанд сард хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх төлбөрийг ажлын байрны төлбөр болгон олгох ба мөн сард дунджаар 80 мянган төгрөгөөр цалинжуулж тэднийг байр сууцаар хангадаг./ Гэхдээ эдгээр ажилтнууд нь мэргэшсэн "ажилчин" байдаг ба тухайлбал: барилга, зам гүүр зэрэг ажлын байранд гадаадын ажилтнууд ихээр ажилладаг нь Монгол ажилтнуудын хувьд заавал дээд мэргэжилтэй байхыг шаардахгүй харин тухайн ажлыг сайн хийх чадвар, чадамжийг шаарддаг. Тиймээс

боловсролын системд эзлэх мэргэжлийн сургалтын хамрах хүрээ, чанарыг нэмэгдүүлэх

- Хөдөлмөр эрхэлж байгаа ажилтнуудын хөдөлмөрийн хөлс, цалин бага, тэдний хөдөлмөрийн үнэлэмж муу байдгаас ихээр гадаадад гарч ажилладаг /Гадаадад ихэвчлэн хар ажил хийдэг ба иргэд гадаадад гарч ажиллаж байгаа тохиолдолд тэдний эзэмшсэн мэргэжил, боловсрол хамаарахгүй, хар ажил л хийдэг. Тиймээс хөдөлмөрийн хөлсний үнэлгээг нэмэгдүүлэх.

- Хөдөлмөрийн зах зээлийн судалгаанд үндэслэн ажлын байрны хэрэгцээг оновчтой тодорхойлох

- Олон улсын жишигт нийцсэн хөдөлмөрийн нэгдсэн бирж байгуулах

- Ядуу иргэдийг засаг захиргааны анхдагч нэгжийн хүрээнд бүртгэлжүүлэх, иргэний бичиг баримтжуулах

- Ядуурлыг бууруулах хөрөнгийн тодорхой хувийг ядуу иргэдийн боловсролын хэрэглээ, шаардлагад зориулах

- Нийгэм хамгааллын салбарт хяналтын тогтолцоог сайжруулах. Ингэснээр нийгмийн даатгалын шимтгэл төлөлт, зохих иргэд тусламжийг авч чадаж байгаа эсэхийг тогтоох

- Төрөөс нийгмийн үйлчилгээг үзүүлэхдээ чанарыг орхигдуулан тоогоор хөөцөлддөгөөс үр дүнг багасаж сөрөг нөлөө нэмэгддэг тул үйлчилгээний чанарын талаарх асуудлыг тухайн хуульд тусга

- Мэдээллийг хүртэж байгаа иргэдийн түвшин харилцан адилгүйгээс ядуу иргэд хохирох нь цөөнгүй байгаа тул мэдээллийг хүргэх, сурталчлах ажлыг нийтийг хамарсан байдлаар явуулах

- Төрөөс эрүүл мэндийн салбарт зарцуулж буй хөрөнгө хүн амын эрүүл мэндийн өсөн нэмэгдэж байгаа хэрэгцээг тэр бүр хангаж чадахгүй учраас хувийн хэвшлийн оролцоог эрүүл мэндийн салбарт бий болгоход илүүтэй анхаарах. Улсын эмнэлгийг хувьчлах аргыг зөв сонгохдоо /удирдлагын гэрээгээр, гүйцэтгэлийн гэрээгээр эсхүл бүрэн хэмжээгээр худалдах/ иргэн бүрт эмнэлгийн чанартай үйлчилгээг хүргэх, эмнэлгийн тоног, төхөөрөмж, багаж хэрэгсэл, үл хөдлөх хөрөнгийн хувьчлал биш харин нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, эмнэлгийн тусламж үйлчилгээг хувийн хэвшилд шилжүүлэх. Эрүүл мэндийн салбарт хувьчлал явагдсанаар эдийн засгийн үр ашиг бий болох, өрсөлдөөн бий болсноор үйлчилгээний чанар сайжирна.

- Өрхийн эмнэлэг нь хүн амд хамгийн ойр болж тэдэнд эрүүл мэндийн анхан шатны тусламжийг үзүүлж, эх хүүхдийн эндэгдэл, халдварт өвчнийг бууруулах, хүн амын эрүүл мэндийн үндсэн үзүүлэлтийг сайжруулахад зохих хувь нэмрийг оруулах учраас түүний эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлагатай байна. Өрхийн эмнэлэг нь хувийн хэвшилд хамаарах уу, эсхүл улсын эмнэлэг үйлчилгээний байгууллага уу гэдгийг нарийвчлан, түүний статусыг тодорхой болгох. Өрхийн эмнэлгээр нийгмийн эрүүл мэндийн болон анхан шатны тусламж үйлчилгээг үзүүлдэг тогтолцоог бий болгох.

- Эрүүл мэндийн даатгалын тогтолцоог боловсронгуй болгох, гадаадын зарим улс орны эрүүл мэндийн даатгалын харилцааг зохицуулсан эх сурвалжийг судалсны үндсэн дээр энэхүү даатгалын санхүүжилтийн эх үүсвэр, түүнийг хуваарилах, хэрэгжилтэнд нь хяналт тавих зохицуулалтыг бий болгох

- Соёл, урлагийн салбарын хөгжлийн стратеги тэргүүлэх чиглэлийг тодорхойлоогүйгээс ямар арга хэлбэрийг хэзээ, хаана, яаж хэрэглэх нь тодорхойгүй, "төрөөс тогтвортой баримтлах бодлого" зөрчигдөхөд хүрч болзошгүй эрх зүйн орчин бүрдсэн байна.

- Соёл урлагийн байгууллагуудыг өөрчлөх, шинэчлэх, хувьчлах стратеги тодорхойгүй

- Соёл урлагийн байгууллагуудын чадамжийг зах зээлийн эрэлт шаардлагад нийцүүлэн дээшлүүлэх системтэй бодлого түүнийг хэрэгжүүлэх зохицуулалтын механизм бий болоогүй байна.

- Соёл, урлагийн байгууллагын бие даан оршин тогтнох чадвар сул байна.
- Өнөөдөр Монголын соёлын амьдралын бүхий л ачаалал БСШУЯ-ны соёл, урлагын бодлого зохицуулалтын газарт 8 хүн үүрч байгаа бөгөөд энэ нь тухайн тулгарсан асуудлыг шийдэхэд хүрэлцэхгүй байна.
- Монгол улсын нэгдсэн төсвөөс хөдөө орон нутгийн соёлын байгууллагуудад тодорхой хэмжээгээр төсвийн санхүүжүүлэлтийг хангахгүй байна./улсаас авч байгаа төсвийг хүрэлцэхгүй байна гэж орон нутгийн соёлын байгууллагуудын дарга нарын 65.4% нь хариулсан байхад үдсэн 34.6% нь хариулт өгөөгүй байна.
- Иргэнийг багаас нь үндэсний соёлын мэдрэмж, мэдлэг, хүмүүжилтэй болгох эрэмбэ дараатай ажлыг бүх шатны боловсролын бүрэлдэхүүн хэсэг болгох
- Төрөөс хяналт тавьж, тодорхой үйл ажиллагааг хориглох хүртэл арга хэмжээ авах
- Хүн амын соёлын хэрэгцээг хангахад *хэвлэл мэдээллийн хэрэгслийн үүргийг өндөржүүлж*, хэвлэлийн чөлөөт байдлыг хангах, ном, кино, хэвлэлийн үйлдвэрлэлийн техник технологийг боловсронгуй болгох, хөгжүүлэх талаар *цогцолбор арга хэмжээ* авч хэрэгжүүлэх
- Хүүхдэд зориулсан сургалтын ном, хэвлэл, уран бүтээлийг олшруулж, чанарыг нь сайжруулах /бага насны хүүхэд/
- Соёлын суурь болон хавсарга судалгааг эрчимтэй хөгжүүлж, түүний үр дүнг нийтийн болон мэргэжлийн сургалтад өргөнөөр ашиглах
- Соёл урлагийн байгууллагын сүлжээг боловсронгуй болгож, дэлхийн жишиг, монгол орны онцлогийг харгалзан *соёлын үйлчилгээний чанарын үзүүлэлтийг тогтоож мөрдүүлэх*
- Соёлын хүрээнд *менежмент, маркетингийг* хөгжүүлэхэд анхаарах
- Соёлын мэргэжлийн боловсон хүчин, багш, судлаач бэлтгэх сургалтын бүх хэлбэр, түүний дотор *гэрийн болон шавь* сургалтыг дэмжих